

2

УУР АМЬСГАЛЫН БОНДЫН СТАНДАРТ, ШААРДЛАГА: Олон улсад

Б.Даваамаа, Д.Хулан

ХУРААНГУЙ

2015 оны Парисын хэлэлцээрийн дагуу гишүүн улс орнууд дэлхийн дундаж температурын өсөлтийг аж үйлдвэржилтийн өмнөх үеийнхээс 2 хэмээс хэтрүүлэхгүй байхаар, агаарын температурын өсөлтийг аж үйлдвэржилтийн өмнөх үеийн түвшингээс 1.5 хэмээр хязгаарлах амлалт өгсөн. Харин Монгол Улс нь нэгдсэн дүнгээр үндэсний хүлэмжийн хийн ялгарлаа нийт ялгаруулах суурь нөхцөлтэй харьцуулахад 2030 он гэхэд 22.7 хувиар буюу 16.89 сая тонн CO₂-тэй дүйцэхүйц хүлэмжийн хийг бууруулах амлалт өгсөн (Монгол Улсын засгийн газрын 407 дугаар тогтоол, 2019). Ийнхүү тус баримт бичгийн хүрээнд 2022 онд Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс “Тогтвортой санхүүгийн үндэсний замын зураг”-ийг баталсан. Тус баримт бичгийн Ногоон, тогтвортой хөгжлийн, уур амьсгалын хөрөнгийн урсгалыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд “Ногоон, уур амьсгалын санхүүгийн бүтээгдэхүүнүүд, санхүүгийн хэрэгслүүдийг стандартчилах боломжийг судлах, нэвтрүүлэх” гэж заасны дагуу энэхүү судалгаагаар уур амьсгалын өрийн хэрэгслийн олон улсын стандарт, баримт бичгүүд болох Ногоон бондын зарчмууд, Уур амьсгалын бондын стандарт, Уур амьсгалын шилжилтийн санхүүгийн гарын авлага болон Япон, Кени, Маврики улсын сайн туршлагыг судалж холбогдох санал, зөвлөмжийг боловсрууллаа.

Түлхүүр үгс: Ногоон бонд, Уур амьсгалын бондын стандарт, Өрийн хэрэгсэл.

JEL ангилал: G1, G10, G28.

СЗХ, ЗЗСХГ-ын ахлах мэргэжилтэн, davaamaa@frc.mn

СЗХ, ЗЗСХГ-ын мэргэжилтэн, khulan@frc.mn

АГУУЛГА >>>

I.	УДИРТГАЛ	50
II.	НОГООН/ ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛД ЧИГЛЭСЭН ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН ТУХАЙ	51
III.	НОГООН/ УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ЧИГЛЭСЭН БОНДЫН ОЛОН УЛСЫН БАРИМТ БИЧИГ	55
	3.1. Ногоон бондын зарчмууд.....	55
	3.2. Уур амьсгалын бондын стандарт.....	56
	3.3. Уур амьсгалын шилжилтийн санхүүгийн гарын авлага	61
IV.	НОГООН/УУР АМЬСГАЛЫН БОНДЫН ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА.....	65
	4.1. Маврики Улс.....	65
	4.2. Кени Улс	70
	4.3. Япон Улс	73
V.	ДҮГНЭЛТ, САНАЛ	76
VI.	АШИГЛАСАН МАТЕРИАЛ	78

ЗУРАГ, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.	Ногоон, Нийгэм, Тогтвортой бондын хамаарал	51
Зураг 2.	Шилжилтийн санхүүжилтийн зураглал	52
Хүснэгт 1.	Бондын тодорхойлолт	52
Хүснэгт 2.	Ногоон/ ТоХ–д бондын давуу тал (хөрөнгө оруулагч)	53
Хүснэгт 3.	Ногоон/ ТоХ–д бондын давуу тал (бонд гаргагч)	54
Хүснэгт 4.	Ногоон бондын зарчмуудын үндсэн 4 бүрэлдэхүүн хэсэг	55
Хүснэгт 5.	Тогтвортой бонд гаргахаас өмнөх, гаргах, гаргасны дараах ерөнхий үйл явцын тойм	66
Хүснэгт 6.	Ногоон/ ТоХ–д чиглэлд хамаарах холбогдох заавар, стандартууд	67
Хүснэгт 7.	Маврики Улсын ногоон/ тогтвортой бондын хүрээний үндсэн 4 зарчим	68
Хүснэгт 8.	Кени Улсын ногоон/ тогтвортой гаргах үндсэн 4 зарчим	71

I. УДИРТГАЛ

Уур амьсгалын өөрчлөлт гэдэг нь урт хугацааны турш дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн улмаас үүдсэн агаар мандал, далай, хуурай газрын дулаарлыг хэлнэ. Уур амьсгалын өөрчлөлт нь амьдрал, биологийн олон янз байдлыг дэмждэг экосистемийн тэнцвэрт байдлыг алдагдуулахын зэрэгцээ хүн, амьтны эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж эхэлсэн (UNDP 2023). Иймд 2020 оноос хүлэмжийн хийн ялгарлыг багасгаж агаар дахь нүүрсхүчлийн хийг бууруулах, дэлхийн дулаарлыг зогсоох зорилгоор Парисын хэлэлцээрийг 2015 онд Нэгдсэн Үндэсний Байгууллага (НҮБ)-ын Уур Амьсгалын Өөрчлөлтийн Суурь Конвенцын 21 дэх чуулга уулзалт (COP21)-ын үеэр соёрхон баталсан. Тус конвенцд нэгдэн орсон улс орнууд дэлхийн дундаж температурын өсөлтийг аж үйлдвэржилтийн өмнөх үеийнхээс 2 хэмээс хэтрүүлэхгүй байхаар, агаарын температурын өсөлтийг аж үйлдвэржилтийн өмнөх үеийн түвшингээс 1.5 хэмээр хязгаарлах хүчин чармайлт гаргах үүрэг хүлээсэн (Sovereign Sustainable Finance Committee 2023). Харин Монгол Улс нь 2016 онд Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын Суурь конвенцын Парисын хэлэлцээрийг соёрхон баталж нэгдсэн дүнгээр үндэсний хүлэмжийн хийн ялгарлаа нийт ялгаруулах суурь нөхцөлтэй харьцуулахад 2030 он гэхэд 22.7 хувиар буюу 16.89 сая тонн –тэй дүйцэхүйц хүлэмжийн хийг бууруулах амлалт өгсөн (Монгол улсын засгийн газрын 407 дугаар тогтоол, 2019). Ийнхүү тус баримт бичгийн хэрэгжилтийг хангахын тулд

Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас Алсын хараа 2050, Шинэ сэргэлтийн бодлого зэрэг бодлогын баримт бичгүүдийг баталж, хэрэгжүүлж байна. Мөн 2022 онд Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс Монгол Улсын тогтвортой хөгжил, уур амьсгалын бүтээн байгуулалтыг эрчимжүүлсэн, нэгдмэл бүтээн байгуулалт, олон талт санхүүгийн бүтээмжийг 2030 он хүртэл нэмэгдүүлэх, бүс нутагтаа санхүүгийн тогтвортой мэдлэг, манлайлах төв болох, үйлдвэрлэлийн стратегийн чиглэл, арга замыг тодорхойлсон **“Тогтвортой санхүүгийн үндэсний замын зураг”**-ийг баталсан. Тус баримт бичгийн Ногоон, тогтвортой хөгжлийн, уур амьсгалын хөрөнгийн урсгалыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд уур амьсгалын санхүүгийн бүтээгдэхүүний зохицуулалтын орчныг бүрдүүлэх, сайжруулах зорилгоор энэхүү судалгаагаар уур амьсгалын өрийн хэрэгслийн олон улсын стандарт болон Япон, Кени, Маврики Улсын ногоон/уур амьсгалын бондын сайн туршлагыг судаллаа.

Уг судалгааны ажил нийт 5 бүлэгтэй. Дараагийн бүлэгт Ногоон/ Тогтвортой хөгжилд чиглэсэн өрийн хэрэгслүүдийн тодорхойлолт, тэдгээрийн ялгаатай байдлын талаар танилцуулна. Судалгааны гурав, дөрөв дүгээр бүлэгт харгалзан Олон улсын ногоон/ уур амьсгалын бондын стандарт, баримт бичгүүд болон олон улсын сайн туршлагын талаар тусгасан. Харин эцсийн тавдугаар бүлэгт дүгнэлт, саналыг оруулав.

II. НОГООН/ ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛД ЧИГЛЭСЭН ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН ТУХАЙ


Ногоон/Тогтвортой хөгжилд чиглэсэн бонд нь ногоон төслүүдийг санхүүжүүлж, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, түүнтэй холбоотой сорилтуудыг шийдвэрлэх чухал хэрэгсэл юм (Worldbank 2021). Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн хүрээлэн буй орчны доройтол, цөлжилт, цаг агаарын гамшигт үзэгдлийн тоо хурдтайгаар нэмэгдэж, хөдөө аж ахуй, хүнс, усны аюулгүй байдал алдагдах эрсдэл нэмэгдэж байна (UNDP 2023). Эдгээр бэрхшээлийг шийдвэрлэх байгаль орчны төслүүдийг хөрөнгийн зах зээл, хөрөнгө оруулагчидтай холбож, хөрөнгийг тогтвортой хөгжилд чиглүүлэх нь чухал бөгөөд ногоон/ тогтвортой хөгжилд чиглэсэн бонд нь энэ холболтыг хийж буй гүүр болж байна.

Маврики Улсын тогтвортой бонд гаргах удирдамжид тодорхойлсноор **Тогтвортой бонд** нь ногоон эсхүл нийгмийн тогтвортой байдалтай холбоотой төслүүдийг санхүүжүүлэх, хөрөнгө босгох замаар тогтвортой хөгжлийн зорилгод чиглэсэн санхүүгийн хэрэгсэл юм.

Харин **уур амьсгалын бонд** нь уур амьсгалын өөрчлөлтийн шийдлүүдэд зориулж санхүүжилт босгох зорилгоор гаргадаг бол **цэнхэр бондын** зарцуулалт нь далай, далайн экосистемийн тогтвортой байдлыг хангахад чиглэдэг. Уур амьсгалын болон цэнхэр бонд нь ногоон бондын дэд хэсэг бөгөөд эдгээр бондын орлогоор хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл нь байгаль орчинд нэмэлт үр өгөөжийг авчирна гэж үзсэн тохиолдолд эдгээр бондыг **ногоон бонд** гэж нэрлэж болдог. Бондыг ялгах гол зүйл нь салбар, төслийн чиглэл болон холбогдох нөлөөллийн үзүүлэлтүүд байдаг. Ногоон/ тогтвортой хөгжилд чиглэсэн бондыг ердийн бондын нэгэн адил засгийн газар, үндэстний банк болон бусад санхүүгийн байгууллагууд гаргаж болно.

Зураг 1–т Ногоон, нийгмийн болон тогтвортой бондын хамаарлыг, *Хүснэгт 1–т* Ногоон/ тогтвортой хөгжилд чиглэсэн бондын төрлүүдийн тодорхойлолтыг тус тус харууллаа.

Зураг 1. Ногоон, Нийгэм, Тогтвортой бондын хамаарал



Эх сурвалж: Guide for the issue of sustainable bonds in Mauritius (2021)

Хүснэгт 1. Бондын тодорхойлолт

Бондын төрөл	Тодорхойлолт
Ногоон бонд	Ногоон бонд нь байгальд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эрсдэлийг бууруулахад чиглэсэн ногоон ангилал зүйн шаардлагыг хангасан төслүүдэд хөрөнгө босгох, хөрөнгө оруулалт хийхэд дэмжлэг үзүүлэх өрийн хэрэгсэл юм.
Цэнхэр бонд	Цэнхэр бонд нь ногоон бондын дэд хэсэг бөгөөд татан төвлөрүүлсэн хөрөнгийг далайн болон эргийн экосистемийг хамгаалахад чиглэсэн, ялангуяа ТХЗ 14–д нийцсэн (Тогтвортой хөгжлийн төлөө далай, далай, далайн нөөцийг тогтвортой ашиглах) төслийг санхүүжүүлэхэд зориулсан хөрөнгө оруулалтын хэрэгсэл юм. Хэрэв тус зорилтын хүрээнд хэрэгжүүлэх төсөл нь байгаль орчинд нэмэлт үр өгөөжийг авчрах тохиолдолд цэнхэр бондыг ногоон бонд гэж нэрлэж болно.
Уур амьсгалын бонд	Уур амьсгалын бонд нь ногоон бондын дэд хэсэг бөгөөд уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, түүнд дасан зохицоход чиглэсэн төслийг санхүүжүүлэх өрийн хэрэгсэл юм. Өөрөөр хэлбэл, орлогын зарцуулалтыг Уур амьсгалын бондын санаачилга (CBI)–тай нийцэж байгааг баталгаажуулсан ногоон бонд юм.
Нийгмийн бонд	Нийгмийн бонд нь бондын орлогыг эрүүл мэнд, боловсрол зэрэг нийгмийн эерэг үр дагавар бүхий төсөл, хөрөнгөд зарцуулахад чиглэсэн өрийн хэрэгсэл.
Тогтвортой байдлын бонд буюу SDG бонд	Тогтвортой байдлын бонд буюу SDG бонд нь Тогтвортой Хөгжлийн Зорилтуудыг (SDGs) биелүүлэх зорилгоор хэрэгжүүлж буй нийгмийн болон байгаль орчны олон төрлийн төслийг санхүүжүүлэхэд зориулсан өрийн хэрэгсэл юм.

Эх сурвалж: *Guide for the issue of sustainable bonds in Mauritius (2021)*

Нэмж дурдахад, 2050 он гэхэд нүүрстөрөгчийн хийг 0 түвшинд хүргэхээ зарласан улс орнуудад ногоон, нийгмийн бондын зарчим болон тогтвортой байдлын бондын удирдамжид нийцсэн өрийн хэрэгсэл буюу Уур амьсгалын шилжилтийн бонд гарч эхэлсэн байна (Зураг 7). **Уур амьсгалын шилжилтийн бонд** нь уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхээр төлөвлөж буй компаниас хэрэгжүүлж буй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад чиглэсэн урт хугацааны

стратеги, төлөвлөгөөг дэмжих санхүүжилт юм. Тус бондын орлогыг газрын тос, байгалийн хий, химийн бодис, цемент, ган зэрэг эдийн засагт чухал ач холбогдолтой боловч богино хугацаанд нүүрстөрөгчийг бууруулах боломжгүй салбаруудад зарцуулдаг бол **уур амьсгалын бонд** нь сэргээгдэх эрчим хүч (салхи, нар), эрчим хүчний хэмнэлт, тээвэр, усны тогтвортой менежмент, хог хаягдлыг бууруулах төслүүдийг санхүүжүүлдэг.

Зураг 2. Шилжилтийн санхүүжилтийн зураглал



Эх сурвалж: *ICMA climate Transition Finance handbook*

Цаашлаад, Ногоон/ Тогтвортой хөгжилд чиглэсэн бонд нь бонд гаргагчид болон хөрөнгө оруулагчдын аль алинд нь хэд хэдэн давуу талуудыг бий олгодог. Тухайлбал, Хөрөнгө оруулагчдын хувьд орлогын менежментийн ил тод байдлыг хянах, тогтвортой байдлын чиглэлд хөрөнгө оруулах боломжийг олгодог

бол бонд гаргагчдын хувьд хөрөнгө оруулагчдыг төрөлжүүлэх, шинэ хөрөнгө оруулагчдыг татах, байгууллагын нэр хүндийг дээшлүүлэх, нийгмийн хариуцлагыг санхүүжилтийн схемтэй холбох, нийцүүлэх боломжийг олгодог. Эмпирик нотолгоонд тулгуурлан мэдээлсэн зарим давуу талуудыг *Хүснэгт 2, 3*-т тус тус харуулав.

Хүснэгт 2. Ногоон/ Тогтвортой хөгжилд бондын давуу тал (хөрөнгө оруулагч)



Эрсдэлийн удирдлагыг сайжруулж, урт хугацааны санхүүгийн өгөөжийг нэмэгдүүлэх: Тогтвортой хөгжилд чиглэсэн хөрөнгө оруулалтын хэрэгслийн гүйцэтгэл нь уламжлалт хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүнтэй харьцуулахад өндөр байдаг. Тухайлбал, орлогын ашиглалт болон төслийн гүйцэтгэл өндөр байх бөгөөд тайлагнал нь ил тод байдаг. Энэ нь эрсдэлийн удирдах хэрэгсэл болдог.



Уур амьсгалын эрсдэлийг шийдвэрлэх: Ногоон бонд нь уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эрсдэлийг бууруулахад тусалдаг. Тухайлбал, ногоон бонд нь эрсдэл багатай бөгөөд ногоон байгууламж гэх мэт уур амьсгалд ээлтэй төсөлд хөрөнгө оруулалт хийдэг.



Хөрөнгө хуваарилалтын босго хэмжээ: Ногоон бондын хөрөнгө оруулалт нь байгууллагын хөрөнгө оруулагчдад багцын хөрөнгийн хуваарилалтын босгыг давах/ хэтрүүлэх боломжийг олгодог.



Нэр хүнд, баталгааг нэмэгдүүлэх: Албан ёсны сертификаттай ногоон бондын зах зээлийн хөгжил нь хөрөнгө оруулагчдад хөрөнгөө хуурамч ногоон хөрөнгө оруулалтын хэрэгсэлд хуваарилахгүй байх баталгааг өгдөг.



Нийгмийн хариуцлагын тогтолцоог санхүүжилтийн схемтэй уялдуулах: Зарим ногоон бондын дотоод эрсдэл, өгөөж нь ижил зэрэглэл бүхий ердийн бондтой ижил байх үед Хөрөнгө оруулагчид “зорилгод суурилсан хөрөнгө оруулалт”-ыг илүүд үздэг.



Ногоон бонд нь хөрөнгө оруулагчдад хөрөнгөө уур амьсгалын өөрчлөлтийн шийдэлд чиглүүлэх боломжийг олгодог. Жишээ нь: Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх дэлхийн хөрөнгө оруулагчдын эвслийн гишүүд 22 их наяд долларыг ногоон, уур амьсгалын өөрчлөлттэй хөрөнгө оруулалтын хэрэгсэлд хөрөнгө оруулсан.



Тэтгэврийн сангуудын хувьд ногоон бондын хөрөнгө оруулалт нь тэтгэвэр авагчдын тэтгэвэрт гарах үед тогтвортой нийгмийг бий болгоход тусална.



Үндэсний хөгжлийн хөтөлбөр, Байгууллагын хөрөнгө оруулагчдын удирдлагын дүрэмд нийцсэн ногоон санхүүгийн салбарт шинийг санаачлагч гэдгээ зах зээлд, цаашлаад олон улсад таниулах.

Эх сурвалж: *The Kenya green bond market: Issuer's Guide (2020)*

Хүснэгт 3. Ногоон/Тогтвортой хөгжилд бондын давуу тал (бонд гаргагч)



Хөрөнгө оруулагчдыг төрөлжүүлэх: Хүлэмжийн хийг бууруулахад чиглэсэн байгаль орчинд ээлтэй бонд нь бонд гаргагчид бүс нутгийн болон бусад олон улс орны хөрөнгө оруулагчдаас хөрөнгө босгох боломжийг олгодог.



Захиалга давж биелэх: Ногоон бондыг зах зээлд гаргах үед ихэнх тохиолдолд эрэлт нь нийлүүлэлтээс давдаг бөгөөд хөрөнгө оруулагчид ногоон бондоо зарах сонирхолгүй байдаг тул хоёрдогч зах зээлд ногоон бонд ерөнхийдөө “sticky” байдаг.



Хөрөнгийн зардал бага: Ногоон бондоор дамжуулан бага зардлаар хөрөнгө босгох нь нүүрстөрөгчийг бууруулахад чиглэсэн дэд бүтцийн хувьд ялангуяа барилгын салбарт хөрөнгө оруулагчдын анхаарлыг ихээхэн татдаг. Учир нь барилга баригдаж дууссаны дараа худалдан авалт харьцангуй өндөр байх хандлагатай байдаг.



Урт хугацааны хөрөнгө оруулалт: Ногоон бондод хөрөнгө оруулагчид ихэнхдээ урт хугацааны хөрөнгө оруулалт хийхийг эрэлхийлдэг. Энэ нь урт хугацааны хөрөнгө оруулалт/ санхүүжилт хайж буй дэд бүтцийн төслүүдэд томоохон тус болдог.



Нэр хүнд: Ногоон бонд гаргахтай холбоотой ил тод байдлыг нэмэгдүүлэх, түүнтэй холбогдох шаардлагууд нь хөрөнгө оруулагчдын сонирхлыг ихээхэн татдаг. Ногоон сертификат нь бонд гаргагчийн нэр хүндийг хөрөнгийн зэх зээлд ихээхэн нэмэгдүүлдэг.



Олон улсын амлалтууд болон Үндэсний хөгжлийн хөтөлбөрт нийцүүлэх: Бонд гаргагч нь Тогтвортой хөгжлийн зорилтуудыг (ТХЗ) хэрэгжүүлэхэд шинийг санаачлагч, манлайлагч гэдгээрээ олон улсад хүлээн зөвшөөрөгддөг.

Эх сурвалж: *The Kenya green bond market: Issuer's Guide (2020)*

III. НОГООН/ УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ЧИГЛЭСЭН БОНДЫН ОЛОН УЛСЫН БАРИМТ БИЧИГ

3.1. НОГООН БОНДЫН ЗАРЧМУУД

Олон улсын хөрөнгийн зах зээлийн холбоо (ICMA)–оос 2021 онд Ногоон бонд гаргах арга замыг тодорхой болгох, ногоон бондын зах зээлийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, шударга байдлыг дэмжих зорилгоор Ногоон бондын зарчмууд (GBP) удирдамжийг гаргасан. Энэхүү ногоон бондын удирдамж нь орлогын ашиглалт,

төслийн үнэлгээ, сонгон шалгаруулалтын үйл явц, орлогын менежмент болон тайлагнах гэсэн үндсэн дөрвөн хэсгээс бүрддэг ба нэмэлтээр тус удирдамжид ногоон бондын танилцуулга, хөндлөнгийн хяналтын талаарх зөвлөмж багтсан.

Хүснэгт 4. Ногоон бондын зарчмуудын үндсэн 4 бүрэлдэхүүн хэсэг

Орлогын ашиглалт	Төслийн үнэлгээ, сонгон шалгаруулалтын үйл явц	Орлогын менежмент	Тайлагнах
<p>–Үнэт цаасны хууль эрх зүйн баримт бичигт бондын орлогыг Ногоон төслүүдэд зарцуулах талаарх зохицуулалтыг тусгах;</p> <p>–Ногоон төсөл нь байгаль орчны хувьд тодорхой үр өгөөжийг бий болгох ёстой ба бонд гаргагч нь үүнийг үнэлэн тоон үзүүлэлтээр тодорхойлох;</p> <p>–Бонд гаргагчид орлогыг бүхэлд нь</p>	<p><i>Ногоон бонд гаргагч нь хөрөнгө оруулагчдад дараахыг тодорхой мэдэгдэх ёстой:</i></p> <p>–Ногоон төслүүдийн байгаль орчин тогтвортой байдлын зорилтууд;</p> <p>–Тус төсөл нь Ногоон төслүүдийн ангилалд нийцэж байгааг тодорхойлох үйл явц;</p> <p>–Бонд гаргагч холбогдох төсөлтэй холбоотой нийгэм, байгаль орчны эрсдэлийг тодорхойлон, түүнийг удирдах үйл явцын талаарх мэдээлэл.</p> <p><i>Бонд гаргагчдыг дараахыг хийхийг зөвлөж байна.</i></p> <p>–Байгаль орчны тогтвортой байдалтай холбоотой Бонд гаргагчийн ерөнхий зорилго, стратеги, бодлого болон/эсвэл үйл явцын хүрээнд дээр дурдсан мэдээллийг байршуулах;</p>	<p>–Ногоон бонд гаргаж татан төвлөрүүлсэн орлого, түүнийг хуваарилалтыг хянах шаардлагатай. Бонд гаргагч нь тухайн орлогыг хянах системийг бий болгож, орлогыг тусгай дэд дансанд байрлуулах замаар зохицуулна. Энэ нь мөнгийг зөвхөн байгаль орчинд эзлэй төслүүдэд, буюу Ногоон төслүүдэд ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.</p> <p>Мөн энэхүү үйл явцыг ногоон төслүүдэд чиглэсэн зээл, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаатай холбон дотооддоо баталгаажуулах ёстой.</p> <p>Ногоон бондын орлогын үлдэгдэл байгаа тохиолдолд тухайн хугацаанд хийгдсэн ногоон төслүүдийн</p>	<p>–Бонд гаргагчид орлого ашиглалтын талаарх шинэчилсэн мэдээллийг орлогыг бүрэн хуваарилах хүртэл жил бүр, аливаа өөрчлөлт гарсан тохиолдолд тухай бүрд гаргаж танилцуулах;</p> <p>–Жилийн тайланд ногоон бондын хөрөнгөөс хуваарилагдсан төслүүдийн жагсаалт, мөн төслүүдийн товч тодорхойлолт, хуваарилсан дүн, тэдгээрийн хүлээгдэж буй үр нөлөөг тусгасан байх;</p> <p>–Нууцлалын гэрээ, өрсөлдөөний асуудал эсвэл олон тооны суурь төслүүдийн нарийвчилсан мэдээллийг задруулах боломжгүй тохиолдолд</p>

эсхүл тодорхой хэсгийн санхүүжилтийн хувийн жингийн тооцоог гаргаж шаардлагатай бол ямар хөрөнгө оруулалт эсвэл төслийн багцад хөрөнгө оруулж байгааг тодруулж мэдээлэх.	–Төслийг ногоон ангилал зүйд нийцүүлэх, холбогдох шалгууруудын талаар мэдээллээр хангах; –Ногоон стандарт, гэрчилгээг ил тод байршуулах; –Холбогдох төсөл(үүд)–ийн нийгэм болон/эсвэл байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн эрсдэлийг бууруулах хүчин зүйлсийг тодорхойлох.	хуваарилалтад нийцүүлэн хянаж, орлогын үлдэгдлийг дахин тохируулж байх; –Бонд гаргагч нь хуваарилагдаагүй бондын орлогын үлдэгдлийг түр хугацаагаар хаана, хэрхэн байршуулах тохиолдолд хөрөнгө оруулагчдад заавал мэдэгдэх ёстой; –Бонд гаргагчийн орлогын хуваарилалтыг хөндлөнгийн аудитор эсвэл бусад гуравдагч этгээдээр баталгаажуулах.	ерөнхий нэр томъёогоор эсвэл багцын үндсэн дүнгийн хувиар танилцуулах; –Гүйцэтгэлийн чанарын үзүүлэлтүүдийг ашиглах, шаардлагатай тохиолдолд гүйцэтгэлийн тоон хэмжүүр, түүнийг тодорхойлоход ашигласан үндсэн аргачлалын талаар тодруулга өгөх.
--	---	---	---

Эх сурвалж: ICMA (2021), *Green Bond Principles: Voluntary Process Guidelines for Issuing Green Bonds*

Түүнчлэн, Ногоон бондын зарчмууд удирдамж нь бонд гаргагчид ногоон бондын хөтөлбөрөө Ногоон бондын зарчмуудын 4 бүрэлдэхүүн хэсэгтэй хэрхэн уялдаж байгаа талаар ногоон бондын танилцуулга холбогдох баримт бичигт тайлбарлах, тус баримт бичгүүдийг хөрөнгө оруулагчдад ойлгоход хялбар хэлбэрээр ашиглах боломжтой байдлаар танилцуулах, төслийг сонгон шалгаруулахдаа ногоон ангилал зүй, ногоон стандарт эсвэл гэрчилгээг

ил тод болгохыг зөвлөдөг. Харин хөндлөнгийн хяналтын хувьд бонд гаргасны дараа хөндлөнгийн аудитор эсхүл бусад гуравдагч этгээдээр ногоон бондын орлогоос төслүүдэд зарцуулж буй хөрөнгийн дотоод хяналт, хуваарилалтыг шалгуулж баталгаажуулахыг зөвлөдөг. Мөн улс орнууд ICMA–гийн хөндлөнгийн хяналтын загварыг ашиглах боломжтой.

3.2. УУР АМЬСГАЛЫН БОНДЫН СТАНДАРТ

Уур амьсгалын бондын стандарт нь уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, түүнд дасан зохицох зорилгоор санхүүжилт босгож буй байгууллагуудад зориулсан сайн дурын схем юм. Энэхүү стандартыг анх 2012 онд Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах чиглэлд хөрөнгө оруулалтыг дайчлах зорилготой ашгийн бус байгууллага болох Уур амьсгалын бондын санаачилга (Climate Bonds Initiative)–аас ногоон бонд болон бусад өрийн хэрэгсэлд итгэх хөрөнгө оруулагчийн итгэлийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх зорилгоор боловсруулсан бөгөөд тус баримт

бичгийн шинэчлэгдсэн хувилбар нь 2024 оны 2 дугаар сард нийтлэгдсэн. Уур амьсгалын бондын стандарт ба баталгаажуулалт нь ICMA–ийн Ногоон бондын зарчмууд дээр суурилдаг ба бонд гаргагч нь орлого ашиглалтын гэрчилгээгээр орлогыг ногоон төсөлд зарцуулна гэдгээ баталгаажуулдаг. Орлого ашиглалтын гэрчилгээ авахад тавигдах шаардлагыг бонд гаргахаас өмнөх болон гаргасны дараах гэж ангилдаг.

Бонд гаргахаас өмнөх гэрчилгээжүүлэлтийн шаардлага

Бонд гаргахын өмнөх гэрчилгээ авах хүсэлтэй бонд гаргагч нь дараах шаардлагыг бүрэн хангасан байна:

- Бонд гаргагч нь дотоод үйл явц, хяналтын тогтолцоо бий болгосон байх;
- Дотоод үйл явц, хяналтын баримт бичиг нь уур амьсгалын бондын стандартад нийцүүлэхэд боломжтой байх;
- Бонд гаргагч нь ногоон өрийн хэрэгслийг гаргахтай холбоотой ногоон бондын зарчмууд (орлого ашиглалт, төслийн үнэлгээ, сонгон шалгаруулалтын үйл явц, орлогын менежмент, тайлагнах үе шат)–ыг хэрхэн хангаж байгааг тайлбарласан баримт бичгийг боловсруулсан байх зэрэг багтана.

Тус баримт бичгийн орлого ашиглалт, төслийн үнэлгээ, сонгон шалгаруулалтын үйл явц, орлогын менежмент, тайлагнах гэсэн 4 бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд дараах мэдээллийг тусгасан байна:

1. Орлогын ашиглалт:

- ✓ Бонд гаргагч нь өрийн хэрэгсэлтэй холбогдох боломжтой төсөл, хөрөнгийг баримтжуулах, түүний жагсаалтыг гаргах ёстой.
- ✓ Бонд гаргагчийн өрийн хэрэгслийн хүлээгдэж буй цэвэр орлого нь санал болгож буй төсөл, хөрөнгөд оруулсан нийт хөрөнгө оруулалтын эрсдэл, нийт дүнгээс ихгүй байна.
- ✓ Бонд гаргагч нь ногоон бондоор хэрэгжүүлэхээр нэр дэвшүүлсэн төсөл, хөрөнгийг бусад бондоор санхүүжүүлэхгүй байх.

2. Төсөл, хөрөнгийг үнэлэх, сонгох үйл явц:

- ✓ Бонд гаргагч нь төсөл, хөрөнгийн сонгох шалгаруулах шийдвэр гаргах үйл явцыг баримтжуулж, хадгалах ёстой.
- ✓ Шийдвэр гаргах үйл явцад дараах зүйлийг авч үзнэ:

- бондын уур амьсгалтай холбоотой зорилго;
- бондын уур амьсгалтай холбоотой зорилтууд (бонд гаргагчийн байгаль орчны тогтвортой байдалтай холбоотой ерөнхий зорилго, стратеги, бодлого);
- бонд гаргах үндэслэл;
- төсөл, хөрөнгө нь уур амьсгалын бондын стандартын шаардлагад нийцэж байгаа эсэхийг тодорхойлсон процесс;
- төсөл, хөрөнгөтэй холбоотой байгаль орчны болон засаглалын материаллаг эрсдэлийг тодорхойлох, удирдах үйл явц;
- төсөл, хөрөнгийг сонгохдоо дурдсан аливаа ногоон стандарт эсвэл гэрчилгээ.

3. Орлогын менежмент:

- ✓ Бонд гаргагч нь орлогыг удирдахад ашиглах систем, бодлого, үйл явцаа баримтжуулж, Баталгаажуулагчид хүргүүлэх ба үүнд дараах зохицуулалтыг багтаасан байх ёстой:
 - орлогыг хянах: өрийн хэрэгслийн цэвэр орлогыг дэд дансанд байршуулах, зохих журмын дагуу хэрхэн хянаж, баримтжуулах талаар;
 - хуваарилагдаагүй цэвэр орлогын үлдэгдлийг хэрхэн удирдах талаар;
 - төсөл, хөрөнгийн санхүүжилтийг удирдах, бүртгэх үйл явц.

4. Тайлагнал:

- ✓ Бонд гаргагч нь ногоон санхүүжилтийн танилцуулгыг боловсруулан бонд гаргахаас өмнө эсвэл гаргах үедээ олон нийтэд мэдээлэх ёстой. Ногоон бондын бодлогын танилцуулгыг баталгаажуулалтын баримт бичгийн нэг болгон Уур амьсгалын бондын стандартын газрын ажлын албанд хүргүүлнэ.

✓ Ногоон бондын танилцуулгад дараахыг тусгасан байх ёстой:

- уур амьсгалын бондын стандарт, Ногоон бондын зарчим эсвэл НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтууд зэрэг холбогдох стандартад нийцсэн тухай;
- орлогын хүлээгдэж буй ашиглалтын талаар;
- төсөл сонгох шийдвэр гаргах үйл явц;
- бонд гаргагчийн орлогыг удирдах үйл явц;
- бонд гаргагчийн тайлагнах, хөндлөнгийн хяналт болон баталгаажуулах үйл явц;
- нэр дэвшүүлсэн төсөл, хөрөнгийн шинж чанар, гүйцэтгэл нь холбогдох салбарын ангилал зүй болон бонд гаргагчийн тодорхойлсон бусад нэмэлт шалгуурт нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах аргачлал, таамаглалын талаарх мэдээлэл;
- хуваарилагдаагүй орлогыг удирдах үйл явц хяналтын талаар;
- уур амьсгалын бондын стандартад нийцэж байгаа эсэхийг дахин баталгаажуулах үед шинэчилсэн мэдээлэл, тайлангуудаар хэрхэн хангах талаарх төлөвлөгөө;
- санхүүжүүлэх төсөл, хөрөнгийн жагсаалт, нэр дэвшүүлсэн төсөл, хөрөнгийн хамаарах хөрөнгө оруулалтын чиглэлийн талаарх мэдээлэл. Тухайлбал, төсөл хөрөнгийн мэдээллийг олон нийтэд ил тод болгоход хязгаарлалт байгаа тохиолдолд яагаад хязгаарлагдмал байгаа талаарх тайлбарыг оруулах;
- бондын орлогын тодорхой хэсгийг дахин санхүүжүүлэхэд ашиглаж байгаа бол дахин санхүүжүүлэхэд төсөл, хөрөнгийн талаарх мэдээлэл.

✓ Олон улсын байгууллагуудын зүгээс Бонд гаргагчдыг санхүүжүүлэх төсөл, хөрөнгийн талаар аль болох их мэдээлэл өгөхийг уриалдаг хэдий ч ихэнх тохиолдолд бонд гаргахаас өмнө төсөл, хөрөнгийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг задруулах боломжгүй байдаг. Энэхүү хязгаарлалт нь төсөл хэрэгжүүлэгчтэй хийсэн нууцын гэрээ, өрсөлдөөнт хүчин зүйлс зэрэг байдлаас шалтгаалан нарийн мэдээллийг задруулахыг хязгаарласан хуулиар зохицуулсан байдаг.

✓ Бонд гаргагч нь олон нийтэд нээлттэй байршуулах мэдээлэлд дараахыг тусгасан байх ёстой.

- нэр дэвшсэн төсөл, хөрөнгийн хөрөнгө оруулалтын чиглэл;
- хуваарилагдаагүй цэвэр орлогыг удирдахад зориулагдсан богино хугацааны хөрөнгө оруулалтын хэрэгслийн төрлүүд;
- баталгаажуулалтын талаар;
- бондын орлогын үлдэгдэлтэй үед уур амьсгалын бондын стандартад нийцэж байгаа эсэхийг дахин баталгаажуулахад шаардлагатай мэдээлэл, тайлангуудыг гаргаж өгөх үйл явц;
- гэрчилгээжүүлэх гэрээнд заасан уур амьсгалын бондын санаачилгаас татгалзах тухай мэдэгдэл.

Бонд гаргасны дараах гэрчилгээжүүлэлтийн шаардлага

Энэ хэсэгт бонд гаргасны дараа гэрчилгээ авахыг хүссэн бонд гаргагч, түүний баримт бичигт тавигдах шаардлагуудыг тодорхойлсон.

1. Орлогын ашиглалт:

✓ Бондын орлогыг төсөл, хөрөнгөд хуваарилсан байх.

✓ бүх төсөл, хөрөнгө нь бонд гаргагчийн ногоон бондын бодлогын баримт бичигт заасан зорилтуудыг хангасан байх.

✓ Бонд гаргагчид бондын орлогын 95–аас доошгүй хувийг салбарын ангилал зүйн шаардлагыг хангасан төсөл, хөрөнгөд хуваарилсан байх ба салбарын шалгуурыг бүрэн хангаагүй төсөл, хөрөнгийг санхүүжүүлсэн орлогын бонд гаргагч нь ногоон бондын бодлогын баримт бичигт дэлгэрэнгүй тодруулга өгөх шаардлагатай.

✓ Салбарын шалгуурыг бүрэн хангаагүй аливаа нэр дэвшүүлсэн төсөл, хөрөнгө нь дараах бүх нөхцөлийг хангасан тохиолдолд хамрагдах боломжтой гэж үзэж болно:

- Уур амьсгалын бондын санаачилгын салбарын ангилал зүйд хараахан ороогүй/ боловсруулаагүй салбаруудтай холбоотой байх;
- Ногоон бондын зарчмууд эсвэл Нийгмийн бондын зарчмуудад тусгасан Ногоон төслийн аль нэг ангилалд багтсан;
- Баталгаажуулах тайлангийн дүгнэлт нь Ногоон/Нийгмийн бондын зарчимтай нийцэж байгаа нь батлагдсан;
- Тус төсөл нь дараах үйл ажиллагааны аль нэгэнд хамаарахгүй байх:
 - Уламжлалт болон уламжлалт бус чулуужсан түлшний нөөцийг хайх, олборлох, тээвэрлэх;
 - Байгалийн хийн үйлдвэрлэл;
 - Түүхий нефтийг боловсруулж бүтээгдэхүүн үйлдвэрлэх;
 - Эрчим хүч үйлдвэрлэх болон дулааны зориулалтаар чулуужсан түлш нийлүүлэх ба/эсвэл ашиглах.

✓ Бонд гаргагч нь өрийн хэрэгсэл гаргаснаас хойш 24 сарын дотор орлогыг төсөл, хөрөнгөд хуваарилах ёстой. 24 сарын эцсийн хугацааг Уур амьсгалын бондын стандартын газрын ажлын алба 5 хүртэл жилээр (мөн санхүүжүүлэх төслүүдийн шинж чанараар зохих ёсоор үндэслэлтэй бол онцгой

тохиолдолд 10 жил хүртэл) сунгаж болно. Хугацааг сунгах үндэслэлийг Бонд гаргагч нотолж, баталгаажуулалт хийгдсэн тохиолдолд сунгалтыг хийнэ. Баталгаажуулалтад заасан хуваарилалтын хугацаа дуусахад Бонд гаргагч нь ахин баталгаажуулалт хийлгэж бонд гаргасны дараах баталгаажуулалтын тайланг Уур амьсгалын бондын стандартын газрын ажлын албаны даргад хүргүүлнэ. Баталгаажуулагч орлогын 100% хуваарилагдсан болохыг батлах хүртэл Бонд гаргагч жил бүр бонд гаргасны дараах баталгаажуулалтын тайланг хүргүүлнэ.

✓ Бонд гаргагч нь албан ёсны дотоод хяналтын тогтолцооны дагуу бондын цэвэр орлогыг хянах ёстой.

✓ Нэмэлтээр санхүүжүүлэх төслийн хувьд тус төсөл нь уур амьсгалын стандартын шаардлагад нийцсэн тохиолдолд төсөл, хөрөнгийн багцад нэмж, оруулж болно.

2. Төсөл, хөрөнгийг үнэлэх, сонгох үйл явц:

✓ Бонд гаргагч нь нэр дэвшүүлсэн төсөл нь цаашид хэрэгжих боломжтой эсэхийг тодорхойлон шийдвэр гаргах үйл явцыг баримтжуулж, хөтөлсөн байх ёстой.

3. Орлогын менежмент:

✓ Бондын орлогыг дэд дансны байршуулж, зохих журмын дагуу тодорхойлж, баримтжуулсан байх ёстой.

✓ Бонд гаргагч нь төсөл, хөрөнгөд орлого хуваарилах үйл явцыг хөтөлж, баримтжуулсан байх ёстой.

✓ Бондын орлогыг төсөл, хөрөнгөд хуваарилах хүртэл дараах байдлаар зохицуулна:

- бэлэн мөнгө, мөнгөний зах зээлийн хэрэгсэл эсвэл бусад хөрвөх чадвартай, богино хугацаат хөрөнгө оруулалтын хэрэгсэлд оруулах;
- аливаа түр зуурын төсөлд богино хугацаат хөрөнгө оруулалтын хэлбэрээр хөрөнгө оруулах.

4. Бонд гаргасны дараах тайлагнал:

✓ Баталгаажсан бонд гаргасны дараа гэрчилгээг хүчинтэй хэвээр нь хадгалахын тулд бонд гаргасан өдрөөс хойш 12–24 сарын дотор шинэчлэлийн тайланг ирүүлэх ёстой.

✓ Бонд гаргагч нь материаллаг өөрчлөлт гарсан тохиолдолд шинэчилсэн тайланг тухай бүр гаргах ёстой. Материаллаг өөрчлөлт гэдэгт эрт эргэн төлөлт, хяналт, худалдан авалт, нэр солигдох, хөрөнгө, шалгуур үзүүлэлт хангасан байдал, гүйлгээний баримт бичигт хийсэн нэмэлт өөрчлөлтүүд, ялангуяа татан буулгах үйл явц, түүний хэрэгжилтийн талаар зэрэг орно.

✓ Бонд гаргагч шинэчилсэн тайлангаа бондын зах зээлийн тайлангийн сувгуудаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

✓ Шинэчлэгдсэн тайлан нь хуваарилалтын тайлан, шалгуур үзүүлэлт, нөлөөллийн тайлан гэсэн гурван төрлийн тайланг агуулна:

- Хуваарилалтын тайлан нь бондын хөрөнгийг эрх бүхий төсөл, хөрөнгөд хэрхэн хуваарилсныг баталгаажуулдаг;
- Шалгуур үзүүлэлтийн тайлан нь холбогдох салбарын ангилал зүйн дагуу төсөл, хөрөнгийн шинж чанар, гүйцэтгэлийг баталгаажуулдаг;
- Нөлөөллийн тайлан нь төсөл, хөрөнгийн хүлээгдэж буй эсвэл бодит нөлөөллийг тусгасан хэмжүүр эсвэл шалгуур үзүүлэлтүүдийг тодруулдаг.

✓ Дээр дурдсан энэхүү тайланг Уур амьсгалын бондын стандартын газрын ажлын албанд хүргүүлж, олон нийтэд мэдээлэх ба бондын үлдэгдэлтэй байх хугацаандаа жил бүр хөрөнгө оруулагчид хүргүүлэх ёстой.

✓ Хуваарилалтын тайланд дараах зүйлийг багтаасан байх ёстой:

- бондын орлого ногоон бондын танилцуулгад тусгагдсан төслүүдэд хуваарилагдсан эсэх, тэдгээр нь

Уур амьсгалын бондын стандарттай нийцэж байгааг баталгаажуулах;

- бондын уур амьсгалтай холбоотой зорилгын талаарх мэдэгдэл;
- цэвэр орлогыг хуваарилсан төсөл, хөрөнгийн жагсаалт;
- төсөл, хөрөнгөд хуваарилсан мөнгөн дүн;
- төсөл, хөрөнгийн мэдээллийг газарзүйн байршлаар мэдээлэх.

✓ Шалгуур үзүүлэлтийн тайланд дараахыг багтаасан байх ёстой:

- санхүүжилт авсан төсөл, хөрөнгө нь гэрчилгээ авах үед тавигдаж байсан шаардлагыг хангасан хэвээр байгааг баталгаажуулсан талаар;
- төсөл, хөрөнгийн гүйцэтгэлийн талаарх мэдээлэл;
- салбарын шалгуурыг бүрэн хангаагүй төсөл, хөрөнгийг санхүүжүүлсэн тохиолдолд хуваарилагдсан орлого, түүний ашиглалтын талаар дэлгэрэнгүй мэдээлэх.

✓ Нөлөөллийн тайлан нь дараахыг багтаасан байх ёстой:

- бондын уур амьсгалтай холбоотой зорилтуудын талаар нэр дэвшүүлсэн төсөл, хөрөнгийн хүлээгдэж буй эсвэл бодит үр дүн, нөлөө;
- төслийн үр дүн, нөлөөллийн гүйцэтгэлийн чанарын үзүүлэлтүүд, боломжтой бол гүйцэтгэлийн тоон үзүүлэлтүүд;
- гүйцэтгэлийн үзүүлэлт, хэмжигдэхүүнийг тооцоолох арга.

✓ Шинэчлэгдсэн тайланд тодорхой төсөл, хөрөнгийн талаарх мэдээлэл хязгаарлагдмал байгаа тохиолдолд яагаад хязгаарлагдмал байгаа талаар тайлбар оруулах.

✓ Бонд гаргагч нь шинэчилсэн тайланг

дэмжих аливаа баталгаажуулалтын тайлан эсвэл бусад холбогдох материалыг олон нийтэд эсвэл бонд эзэмшигчдэд нээлттэй мэдээлэх ёстой.

Гэрчилгээг хүчингүй болгох

✓ Гэрчилгээ авсан Бонд гаргагч нь Уур амьсгалын бондын стандартын газрын ажлын албанаас нэмэлт мэдээлэл хүссэн тохиолдолд даруй хүргүүлэх ёстой.

✓ Уур амьсгалын бондын стандартыг зөрчсөн гэж үзсэн тохиолдолд Уур амьсгалын бондын стандартын газрын ажлын алба нь Уур амьсгалын бондын стандартын дагуу баталгаажуулалтыг өөр Баталгаажуулагчаар баталгаажуулалт хийлгэж шинэ тайлан гаргахыг шаардаж болно:

- энэхүү баталгаажуулалтын тайланг анх хүсэлт гаргаснаас хойш гурван сарын дотор Уур амьсгалын бондын стандарт ажлын албанд хүргүүлнэ;
- Уур амьсгалын бондын стандартын газрын ажлын алба бонд гаргаснаас 6 сарын хугацаанд баталгаажуулалтын тайланг шаардаж болно.

✓ Бонд нь уур амьсгалын бондын стандартад нийцэхгүй болсон тохиолдолд бонд гаргагч нь зөрчлийг мэдсэнээс хойш 1 сарын

дотор Уур амьсгалын бондын стандартын газрын ажлын албанд энэ тухайгаа мэдэгдэх ёстой. Уур амьсгалын бондын стандартын нарийн бичгийн дарга нарын газар нь тус зөрчлийг залруулах арга хэмжээг санал болгож болно. Эсрэг тохиолдолд тухайн бондын гэрчилгээг цуцална.

✓ Уур амьсгалын бондын стандартын газрын ажлын алба бондын гэрчилгээг цуцалсны дараа бонд гаргагч нь:

- гэрчилгээний тэмдгийг өрийн хэрэгсэлтэй холбон хэрэглэхгүй байх;
- гэрчилгээжүүлэлтэй холбоотой жагсаалт эсвэл индексээс өрийн хэрэгслийг хасах шаардлагатай бүх арга хэмжээг авах;
- гэрчилгээний статус өөрчлөлтийн талаар хөрөнгө оруулагчид, холбогдох биржүүд болон бусад талуудад мэдэгдэх.

✓ Уур амьсгалын бондын стандартын газрын ажлын албанаас гэрчилгээгээ цуцалсан тохиолдолд бонд гаргагч нь Уур амьсгалын бондын стандартын өргөдөл, гомдлын бодлогоор дамжуулан шийдвэрийг давж заалдаж болно.

3.3. УУР АМЬСГАЛЫН ШИЛЖИЛТИЙН САНХҮҮГИЙН ГАРЫН АВЛАГА

2020 болон 2023 онд Олон улсын хөрөнгийн зах зээлийн холбооноос Уур амьсгалын шилжилтийн санхүүгийн гарын авлагыг гаргасан. Энэхүү гарын авлага нь уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийн асуудлыг шийдвэрлэх хүсэлтэй хөрөнгө оруулагчид бонд гаргагчид хоорондын санхүүжилтийн үр ашигтай урсгалыг хангах ба хөрөнгө босгох үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ, практик, тодруулгын талаар хөрөнгийн зах зээлд оролцогчдод тодорхой удирдамж,

нийтлэг хүлээлтийг хангах зорилготой.

Тус гарын авлага нь дөрвөн хэсгээс бүрдэнэ:

- Бонд гаргагчийн уур амьсгалын шилжилтийн стратеги ба засаглал;
- Бизнес загварын материаллаг байдал;
- Уур амьсгалын шилжилтийн стратеги нь «шинжлэх ухаанд суурилсан» зорилтууд болон замын зургийг багтаасан байх;

- Хэрэгжилтийн ил тод байдал.

Энэхүү гарын авлагад тусгасан тодруулга, зөвлөмж холбогдох шаардлагын талаар компанийн жилийн тайлан, үндсэн баримт бичиг, эсвэл хөрөнгө оруулагчийн танилцуулгад тусгана. Мөн дээрх 4 хэсэгт тусгасан хөндлөнгийн хяналт, баталгаажуулалтыг баримт бичгийн нэг хэсэг хоёрдогч талын дүгнэлт болгон оруулах эсхүл бонд гаргагчийн Байгаль орчин нийгэм засаглалын тайлангийн хүрээнд гаргаж болно.

1. Бонд гаргагчийн уур амьсгалын шилжилтийн стратеги ба засаглал

Бонд гаргагчийн санхүүжилт босгох гол зорилго нь уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, дасан зохицох стратегийг хэрэгжүүлэхэд чиглэх ёстой бөгөөд уур амьсгалын шилжилтийн стратеги нь нүүрстөрөгч багатай эдийн засагт шилжихэд эерэг хувь нэмэр оруулахын тулд бизнесийн загвараа ямар төлөвлөгөөний дагуу, арга барилаар хэрхэн өөрчилж, тохируулахыг зорьж буйг тодорхой тусгасан байх ёстой.

Ил тод байдал

Байгууллагын стратегитай холбоотой ил тод байдлыг Уур амьсгалтай холбоотой санхүүгийн тодруулгын ажлын хэсгийн зөвлөмж (TCFD) зэрэг хүлээн зөвшөөрөгдсөн тайлагналын тогтолцоотой нийцүүлэх боломжтой эсхүл компанийн уламжлалт тайлагналтай холбоотой практикаар буюу жилийн тайлан, тусгай зориулалтын тогтвортой байдлын тайлан, хөрөнгө оруулагчдад зориулсан танилцуулгад тусгаж болно. Тайлагналд тусгах гол үзүүлэлтүүд:

✓ Парисын хэлэлцээрийн зорилгод нийцүүлэх урт хугацааны зорилт (жишээлбэл, дэлхийн дулаарлыг 1.5°C хүртэл, хамгийн багадаа 2°C-ээс их хэмжээгээр хязгаарлах зорилго);

✓ Урт хугацааны зорилгод хүрэх замд холбогдох завсрын зорилтууд;

✓ Нүүрстөрөгчийг бууруулахад чиглэсэн бонд гаргагчийн хөшүүргийг тодруулж, Парисын хэлэлцээрийн зорилгод нийцүүлэх урт хугацааны зорилтод чиглэсэн стратеги төлөвлөлт;

✓ Шилжилтийн стратегийн тодорхой хяналт, засаглал;

✓ Байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөллийг бууруулах, НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтуудад хувь нэмрээ оруулах илүү өргөн хүрээтэй тогтвортой байдлын стратегийн нотолгоо.

Хөндлөнгийн хяналт, баталгаажуулалт

Стратеги төлөвлөлтийн хөндлөнгийн хяналт, баталгаажуулалт нь уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийн асуудлыг шийдвэрлэхийн тулд бонд гаргагчийн стратегийн найдвартай байдлын талаарх хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэхэд тусална. Энэхүү хяналт, дүгнэлт дараахыг агуулсан байна:

- урт болон богино хугацааны зорилтуудыг ерөнхий хувилбартай уялдуулсан байдал;
- бонд гаргагчдын стратегийн зорилтод хүрэх найдвартай байдал;
- бонд гаргагчийн уур амьсгалын шилжилтийн стратегийн бие даасан засаглалын түвшин ба хяналт (ТУЗ-ийн хөндлөнгийн гишүүд, бонд гаргагчийн уур амьсгалын шилжилтийн стратегийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар оруулах эсхүл холбогдох бусад ТУЗ-ийн тусгайлсан дэд хороод).

2. Бизнес загварын материаллаг байдал

Уур амьсгалын шилжилтийн бонд нь бизнесийн үндсэн үйл ажиллагаанд уур амьсгалын шилжилтийн стратегийг хэрэгжүүлэхэд

шаардагдах санхүүжилт байх ёстой. Уур амьсгалын өрийн хэрэгсэл гаргахтай холбоотой шилжилтийн замын зураг нь нэг удаагийн биш харин бизнесийн загварын ирээдүйн амжилтад чухал хүчин зүйл болдог. Иймд тус замын зураг/стратеги нь бонд гаргагчийн байгаль орчин, нийгэмд үзүүлэх уур амьсгалын нөлөөллийн ач холбогдлыг харгалзан үзэж, сөрөг нөлөөллийг бууруулахыг эрэлхийлсэн байх ёстой.

Ил тод байдал

Төлөвлөсөн шилжилтийн замын зургийн материаллаг байдлын талаарх хэлэлцүүлгийг дээр дурдсан 1 дүгээр хэсэгт дурдсан тайлагналд оруулна. Ийнхүү ил тод байдлыг тайлагнахдаа материаллаг байдлын талаар одоо мөрдөгдөж буй баримт бичиг тухайлбал, нягтлан бодох бүртгэлийн стандартын байгууллагаас гаргасан холбогдох удирдамжийг ашиглаж болно.

Уур амьсгалын шилжилтийн төлөвлөгөөний стратегийн бодит байдлын талаарх хэлэлцүүлэг нь дараахыг тусгасан байна:

- бонд гаргагчаас нийтэд зарласан материаллаг байдлыг ил тод байдлаар жилийн тайланд тусгагдсан байх;
- бонд гаргагчийн нийт ялгарлын хэмжээг бууруулах зохих төслүүдийн материаллаг байдлын асуудлыг шийдвэрлэх. Материаллаг байдлыг хараахан бүрэн тодорхойлоогүй эсвэл хэмжигдээгүй байгаа тохиолдолд тайлагнах цаг хугацааг заавал ил тод болгох ёстой.

Хөндлөнгийн хяналт, баталгаажуулалт

Санхүүгийн тайлан, тодруулга гэх мэт баримт бичигт хөндлөнгийн хяналт хийж болно.

3. Уур амьсгалын шилжилтийн стратеги нь шинжлэх ухааны үндэслэлтэй байх (зорилтууд, замын зураг);

Бонд гаргагчийн уур амьсгалын стратеги нь шинжлэх ухаанд суурилсан зорилтууд болон шилжилтийн замын зурагтай байх ёстой. Төлөвлөсөн шилжилтийн замын зураг нь дараах шаардлагыг хангасан байна:

- тоогоор хэмжигдэхүйц байх (цаг хугацааны хувьд тогтвортой хэмжилтийн арга зүйд суурилсан);
- шинжлэх ухааны үндэслэлтэй, нийцүүлэх, харьцуулах боломжтой байх;
- олон нийтэд мэдээлэх (үндсэн санхүүжилтийн мэдүүлэгт хамгийн тохиромжтой), завсрын үе шатуудыг багтаасан байх;
- бие даасан баталгаа эсвэл баталгаажуулалт хийгдсэн байх.

Мөн энэхүү хэсэгт Парисын хэлэлцээрт нийцсэн байдал, зах зээл болон оролцогч талуудын хүлээлт, компанийн гарааны цэг, ололт амжилт, эдийн засгийн хязгаарлалт/зардал–үр ашгийн шинжилгээ, баталгаат техник, технологи байгаа эсэх талаар тусгана.

Ил тод байдал

Уур амьсгалын шилжилтийн төлөвлөгөөнд дараах ил тод байдлын мэдээлэл, үзүүлэлтүүдийг тусгана:

- Уур амьсгалын шилжилтийн ерөнхий стратеги болон уур амьсгалын шинжлэх ухаанд нийцсэн хөрөнгө оруулалтын зардлын төлөвлөгөө, энэхүү төлөвлөгөө нь байгууллагын хөрөнгө оруулалтын зардлын шийдвэр гаргахад хэрхэн тусгагдсан тухай хэлэлцүүлэг;

- Уур амьсгалын шилжилтийн стратегид үл нийцэх үйл ажиллагаа/ бүтээгдэхүүнийг үе шаттайгаар зогсоох төлөвлөгөө;
- Ногоон бондын зарчмуудад хамаарах боломжтой ногоон төслийн ангилалд дурдсан төслүүдийг нийт хөрөнгө оруулалтын зардлын хувиар илэрхийлж, энэ харьцаа цаг хугацааны явцад хэрхэн өөрчлөгдөхийг тооцоолох;
- Гол тоног төхөөрөмж, бүтээгдэхүүнээс гарч болзошгүй хүлэмжийн хийн ялгаралтын чанарын болон/эсвэл тоон үнэлгээ;
- Нүүрстөрөгчийг бууруулах дотоод зардлын талаарх таамаглал;
- Ажиллах хүчин, олон нийт, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, тэдгээр сөрөг нөлөөллийг бууруулахад ашигласан холбогдох стратегийн талаарх тодруулга.

Хөндлөнгийн хяналт, баталгаажуулалт

Хяналт баталгаажуулалтын хувьд “нүүрстөрөгчийг бууруулах замын зураг” – ыг хянаж энэ нь 1 дүгээр хэсэгтэйгээ хэр зэрэг нийцэж байгаа талаар санал дүгнэлт гаргах зорилготой хөндлөнгийн хяналтын үйлчилгээг зөвлөдөг. Хэрэв тодорхой баталгаа, баталгаажуулалт хийгдээгүй бол бонд гаргагч нь хөрөнгө оруулалт болон үйл ажиллагааны зардлын төлөвлөгөөнүүд нь хүлэмжийн хийг бууруулах стратегийг хэрхэн дэмжих төлөвтэй байгаа талаар хэтийн төлөвтэй дүн шинжилгээ хийх ёстой. Ерөнхийдөө хэд хэдэн хэмжүүрээр хянаж болно:

- бонд гаргагчийн ногоон/тогтвортой байдлын зардлын нийт зардалд эзлэх хувь;

- ногоон/тогтвортой байдлын зардлын хэмжээ;
- Хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах үр дүн эсвэл ногоон/тогтвортой байдлын бондын зарцуулалтаар хүрсэн эсвэл хүрэхээр хүлээгдэж буй үр өгөөж, мөн ногоон бус үйл ажиллагаанд зарцуулсан зардлын бууруулсан хэмжээ.

4. Хэрэгжилтийн ил тод байдал

Бонд гаргагчийн уур амьсгалын шилжилтийн стратегийг санхүүжүүлэх зорилготой хөрөнгө босгох зах зээлийн харилцаанд хөрөнгө оруулалт, судалгаа хөгжүүлэлтийн зардал, үйл ажиллагааны зардлын дэлгэрэнгүй мэдээлэл болон засаглал, үйл явцын өөрчлөлт зэргийг үндсэн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн боломжит хэмжээнд ил тод байлгах ёстой.

Ил тод байдал

Хөрөнгө оруулалтын зардал, үйл ажиллагааны зардлын төлөвлөгөө болон бусад холбогдох санхүүгийн мэдээлэл болон шилжилтийн стратегитай холбоотой мэдээллийг компанийн жилийн тайлан, вэбсайт эсвэл тогтвортой байдлын тайлангаар дамжуулан гаргаж болно. Урьдчилан тооцоолсон үнийн дүнгийн дагуу тодорхой элементүүд болон зарласан стратегитай тэдгээрийн холболтыг нарийвчлан харуулсан энгийн хүснэгтийн хэлбэрээр хүлээгдэж буй хөрөнгийн болон төлбөрийн баримтуудыг тодруулах боломжтой. Тайлагналд тусгах гол үзүүлэлтүүд:

- Дээрх 1 дүгээр хэсгийн ил тод байдалд тодорхойлсон үзүүлэлтүүдийн дагуу хөрөнгө/орлого/зарлагын хувь хэмжээний талаарх тайлан;
- Ерөнхий стратеги болон уур амьсгалд нийцсэн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлт.

Хөндлөнгийн хяналт, баталгаажуулалт

Дээр дурдсан хэтийн төлөвтэй зардлын төрлийг үнэн зөв урьдчилан таамаглахад хүндрэлтэй байдаг тул хөрөнгө оруулалтын болон ашиглалтын төлөвлөгөөний баталгаажуулалт (жишээлбэл, зарлага анх төлөвлөсний дагуу хийгдсэн эсэхийг үнэлэх) тохиромжгүй байх

магадлалтай. Иймд компани өөрөө үр дүн нь анхны төлөвлөгөөтэй хэр зэрэг нийцэж байгаа, тухайлбал, зарцуулалт нь хүлээгдэж буй байдлаар хийгдсэн эсэх, мөн хийгээгүй тохиолдолд шалтгааны талаар тайлбар өгөх талаар дүн шинжилгээ хийж танилцуулна.

IV. НОГООН/УУР АМЬСГАЛЫН БОНДЫН ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

4.1. МАВРИКИ УЛС

2016 онд Маврики Улсын Засгийн газар Тогтвортой хөгжлийн зорилтуудад хүрэхийн тулд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс дэмжлэг хүссэн ба тус хөтөлбөрийн баг Маврики Улсад төлөөлөгчийн газраа байгуулан “2030 он хүртэлх хэрэгжүүлэх тогтвортой хөгжлийн замын зураг”-ийг боловсруулахад дэмжлэг үзүүлсэн. Энэ хүрээнд өгсөн гол зөвлөмжүүдийн нэг нь Маврики улсын ногоон санхүүжилтийн тогтолцоог бий болгож, ногоон, тогтвортой бонд зэрэг санхүүгийн шинэлэг хэрэгслийг гаргах байсан. Иймд 2021 онд Төв банк, Санхүүгийн үйлчилгээ, сайн засаглалын яам, Санхүүгийн үйлчилгээний хороо (FSC), Маврикийн хөрөнгийн бирж (SEM) болон Стандартын төлөөлөгчдөөс бүрдсэн техникийн хороог байгуулсан ба тус хороо нь Дэлхийн банк болон Францын хөгжлийн агентлагаас

чиглэл авч дотоодын тогтвортой бондын зах зээлийг хөгжүүлэх чиглэлд ажиллаж эхэлсэн. Мөн НҮБ-ын Суурин төлөөлөгчийн газар нь тус техникийн хорооны зөвлөхөөр ажилласан. Ийнхүү 2021 онд Маврики Улсын тогтвортой санхүүжилтийн экосистемийн бүрэн бүтэн байдлыг хангах, бусад зүйлсийн дунд «ногоон угаалт»-аас урьдчилан сэргийлэх зорилго бүхий ногоон/тогтвортой бонд гаргахад тавигдах шаардлага, үйл явцын талаарх удирдамжийг боловсруулж олон нийтэд нийтэлсэн.

Бонд гаргах үйл явц

Ногоон/Тогтвортой бонд гаргах үйл явцыг гаргахаас өмнөх, гаргах, гаргасны дараах үе шат хэмээн ерөнхий ангилдаг ба тус ерөнхий үйл явцын тоймыг *Хүснэгт 5*-д харуулав.

Хүснэгт 5. Тогтвортой бонд гаргахаас өмнөх, гаргах, гаргасны дараах ерөнхий үйл явцын тойм

ҮЕ ШАТ	ГАРГАХААС ӨМНӨ	ГАРГАХ	ГАРГАСНЫ ДАРАА
АНХААРАХ	Бонд гаргагчийн ногоон бондын танилцуулга боловсруулах	Санал болгоход бэлтгэх, санал болгох	Хяналт, тайлагналт
АЛХАМ 1	Орлогын зорилтот ашиглалтын талаарх холбогдох баримт бичгийг бий болгох;	Хуулийн хүрээнд холбогдох баримт бичгийг бэлтгэх;	Орлогыг бонд гаргагчийн ногоон / нийгмийн/ тогтвортой бондын тогтолцоонд нийцүүлэн удирдах;
АЛХАМ 2	Төслийн үнэлгээ, сонгон шалгаруулалтын үйл явцыг тодорхойлох;	Санал болгох зөвшөөрөл авах;	Ногоон /нийгмийн/ тогтвортой байдлын төслүүдэд нөөцийн хуваарилалтын тайлан гаргах;
АЛХАМ 3	Орлогыг хэрхэн захиран зарцуулахыг тогтоох;	Саналыг нээх;	Бонд гаргагч нь ногоон /нийгмийн/ тогтвортой байдлын төслүүдийн төлөв байдлын шинэчлэлтийг өгөхийн тулд холбогдох гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (KPI)-ийн талаар тайлагнаж болно.
АЛХАМ 4	Хөндлөнгийн үнэлгээ хийх.	Санал түгээх, хуваарилах.	

Эх сурвалж: Guide for the issue of sustainable bonds in Mauritius (2021)

Гаргахаас өмнөх үе шат:

Бонд гаргагчийн ногоон/нийгмийн/тогтвортой бондын бодлогын баримт бичгийг бий болгох:

Ногоон/ Тогтвортой бондын хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэхийн тулд засаглал, ил тод байдлыг, ялангуяа “ногоон” / “нийгмийн” / “тогтвортой байдал” тал дээр илүү анхаарах хэрэгтэй ба ногоон бонд гаргах үйл явц нь энгийн бондын үйл явцтай төстэй.

Тогтвортой бондыг гаргах алхмууд:

1. Ногоон / Нийгмийн / Тогтвортой байдлын бондын бодлогын баримт бичгийг бий болгох;
2. Хөндлөнгийн хяналт шалгалт хийх;
3. Бондоо зах зээлд гаргах.

Ногоон/ Тогтвортой хөгжилд чиглэсэн бонд гаргагчид юуны өмнө санхүүжүүлэх төслийн төрөл, орлогын ашиглалт, орлогын удирдлага,

бонд гаргагчийн тайлагнах үйл явцыг нарийвчлан тусгасан баримт бичгийн төсөл буюу бондын хүрээний төслийг боловсруулах шаардлагатай.

Ногоон бондын хувьд бонд гаргагчид нь IC–MA–аас гаргасан Ногоон бондын зарчим, Уур амьсгалын бондын стандарт, ангилал зүй болон бусад тогтоосон стандарттай нийцүүлэх шаардлагатай. Ногоон бондын зарчим болон Уур амьсгалын бондын санаачилгаас гаргасан ангилал зүйд нийцсэн ногоон төслүүдэд хамрагдах хэд хэдэн өргөн ангилал байдаг бөгөөд үүнд:

- ✓ Сэргээгдэх эрчим хүч;
- ✓ Эрчим хүчний хэмнэлт;
- ✓ Бохирдлоос урьдчилан сэргийлэх, хянах;
- ✓ Амьд байгалийн баялаг, газар ашиглалтын байгаль орчинд ээлтэй тогтвортой менежмент;

- ✓ Газрын болон усны биологийн олон янз байдлыг хамгаалах;
 - ✓ Тээвэрлэлт;
 - ✓ Ус, усны тогтвортой менежмент;
 - ✓ Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох;
 - ✓ Эко хэмнэлттэй эсвэл тойрог эдийн засагт тохирсон бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн технологи, үйл явц;
 - ✓ Бүс нутаг, үндэсний болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт, гэрчилгээг хангасан ногоон байгууламж.
- Мөрийтэй тоглоом, казино болон түүнтэй адилтгах аж ахуйн нэгжүүд;
 - Цацраг идэвхт бодис үйлдвэрлэх, худалдаалах (энэ нь эмийн худалдан авалтад хамаарахгүй);
 - Албадан хөдөлмөр/хүүхдийн хор хөнөөлтэй хөдөлмөрийн хор уршигтай, мөлжлөгийн хэлбэр бүхий үйлдвэрлэл, үйл ажиллагаа;
 - Тогтвортой менежменттэй ойгоос бусад мод болон ойн бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдаалах;
 - Үндэсний хууль тогтоомж, дүрэм журам, олон улсын конвенци, хэлэлцээрийн дагуу хууль бус гэж тооцогдсон аливаа бүтээгдэхүүн, үйл ажиллагааг үйлдвэрлэх, худалдаалах.

Тодорхой үйл ажиллагааг дэмжих эсвэл сурталчлах дараах төслүүдийг ногоон/Тогтвортой хөгжилд чиглэсэн өрийн хэрэгслээр санхүүжүүлэхийг хориглоно. Үүнд:

- Газрын тосны хайгуул, олборлолт;
- Зэвсэг, сумны үйлдвэрлэл, худалдаа;
- Согтууруулах ундааны үйлдвэрлэл, худалдаа;
- Тамхины үйлдвэрлэл, худалдаа;

Бонд гаргагч нь гаргах бондын төрлөөс хамааруулан ногоон/Тогтвортой хөгжилд чиглэсэн бондын баримт бичгээ *Хүснэгт 6*-д заасан стандартуудтай уялдуулна.

Хүснэгт 6. Ногоон/Тогтвортой хөгжилд чиглэлд хамаарах холбогдох заавар, стандартууд

БОНДЫН ТӨРӨЛ	СТАНДАРТ
Ногоон бонд	ICMA-ийн Ногоон бондын зарчмууд, Уур амьсгалын бондын санаачилга (CBI)-ын Уур амьсгалын бондын стандарт, ангилал зүй эсвэл бусад тогтоосон стандартын дагуу;
Цэнхэр бонд	ICMA-ийн Ногоон бондын зарчмууд, Уур амьсгалын бондын санаачилга (CBI)-ын Уур амьсгалын бондын стандарт, ангилал зүй эсвэл бусад тогтоосон стандартын дагуу.
Уур амьсгалын бонд	ICMA-ийн Ногоон бондын зарчмууд, Уур амьсгалын бондын санаачилга (CBI)-ын Уур амьсгалын бондын стандарт, ангилал зүй эсвэл бусад тогтоосон стандартын дагуу.
Нийгмийн бонд	ICMA-ийн Нийгмийн бондын зарчмууд.
Тогтвортой байдлын бонд эсвэл SDG бонд	ICMA-ийн Ногоон бондын зарчмууд ба ICMA-ийн Нийгмийн бондын зарчмууд.

Эх сурвалж: Guide for the issue of sustainable bonds in Mauritius (2021)

Дээр дурдсанчлан бондын танилцуулга, зарчим заавал тусгагдсан байх ёстой (*Хүснэгт 7*).
бодлогын баримт бичигт дараах үндсэн 4

Хүснэгт 7. Маврики улсын ногоон/ тогтвортой бондын хүрээний үндсэн 4 зарчим

ЗАРЧИМ	ТОДОРХОЙЛОЛТ
1. ОРЛОГЫГ АШИГЛАХ	<p>Бондын орлогыг Ногоон/Нийгмийн төслүүдийг санхүүжүүлэх эсвэл дахин санхүүжүүлэхэд ашиглах бөгөөд үүнийг зохицуулагч байгууллагад хүргүүлэх эрх зүйн баримт бичигт зохих ёсоор тайлбарласан байх ёстой.</p> <p>Бүх сонгогдсон ногоон төслүүд нь байгаль орчны тодорхой үр өгөөжийг өгөх ёстой бөгөөд боломжтой бол бонд гаргагч тоон үзүүлэлтээр тооцож, тодруулга хийх.</p> <p>Ногоон/Нийгмийн ямар төсөл, хөрөнгө, арга хэмжээг санхүүжүүлэх, санхүүжилтийг хэрхэн удирдаж, хуваарилахаа тодорхойлж, ил тод болгох шаардлагатай.</p> <p>Ногоон төслүүд аль тогтвортой хөгжлийн зорилтод хэрхэн хувь нэмэр оруулж буйг олон нийтэд мэдээлэх.</p>
2. ТӨСЛИЙН ҮНЭЛГЭЭ, СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ҮЙЛ ЯВЦ	<p>Бонд гаргагч нь бонд гаргахаас өмнө дараах мэдээллийг Санхүүгийн зохицуулагч байгууллага, хөрөнгө оруулагчид болон Үнэт цаасны биржид нээлттэй мэдээлэх ёстой:</p> <ul style="list-style-type: none">• Санал болгож буй төслийг шаардлага хангасан эсэхийг үнэлэх эсхүл Ногоон/Нийгмийн төсөл хэрхэн ангилж байгааг үнэлэх дотоод үйл явц;• Санал болгож буй төслийн байгаль орчны / нийгмийн хүлээгдэж буй үр өгөөж;• Санал болгож буй төслийг сонгох, батлахтай холбоотой дотоод үйл явц;• Санал болгож буй төсөлд иш татсан аливаа стандарт, гэрчилгээ;• Хүрээлэн буй орчин/нийгмийн болзошгүй эрсдэлийг тодорхойлох үйл явц.• Тогтвортой бондын баримт бичигт ашигласан аливаа стандарт, гэрчилгээ, хөндлөнгийн шалгалтын үр дүнг тодорхой тусгагдсан байх ёстой.
3. ОРЛОГЫН МЕНЕЖМЕНТ	<p>Бонд гаргагч нь өөрийн чадавхын хэрээр орлогыг хэрхэн удирдах үйл явцыг тодорхой тайлбарлах ёстой:</p> <ul style="list-style-type: none">• Бондын орлогыг дэд данс нээж байршуулах;• Ногоон бондын эх үүсвэрээр зээл олгох болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулахтай холбоотой албан ёсны дотоод журам баталж мөрдөх;• бондын үлдэгдэлтэй байгаа тохиолдолд бонд гаргагч ногоон дансыг төслийн зардалтай тулгалт хийж, хуваарилагдаагүй үлдэгдлийг хэрхэн байршуулж байгаа талаар хөрөнгө оруулагчдад мэдэгдэх. <p>Дотоод хяналт, хуваарилалтын үйл явцыг шалгахын тулд аудитор эсвэл гуравдагч этгээдээр хөндлөнгийн хяналт хийлгэнэ..</p>
4. ТАЙЛАГНАХ	<p>Бонд гаргагч шаардлага хангасан ямар ямар төслүүдэд орлогыг хуваарилсан тухай тайлагнана. Энэ нь ихэвчлэн жилийн тайланд тусгагдаж болох бөгөөд зохих төслүүдийн жагсаалтыг гаргаж, төслүүдийн товч тайлбарыг өгч, холбогдох хуваарилалтыг зааж өгнө. Мөн орлого хуваарилалтын ил тод байдал, хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэхийн тулд илүү олон удаа тогтмол тайлан гаргаж болно. Тухайлбал орлогын ашиглалтын тайлан, аудит/баталгаажуулалтын тайлан, ESG/тогтвортой байдлын тайланд тусгаж болно.</p>

Гаргасны дараа үе шат:

Хөндлөнгийн хяналт, баталгаажуулалт

Хөндлөнгийн хяналт, баталгаажуулалтын хувьд тогтвортой бонд гаргахтай холбогдуулан бонд гаргагчид байгаль орчны тогтвортой байдал болон тогтвортой бонд гаргах бусад асуудлаар хүлээн зөвшөөрөгдсөн хөндлөнгийн хяналтын үйлчилгээ үзүүлэгчийг томилохыг зөвлөдөг. Хөндлөнгийн хяналтын үйлчилгээ үзүүлэгч нь бонд гаргагчаас хараат бус байх ёстой. Түүнчлэн, Хөндлөнгийн хяналтын үйлчилгээ үзүүлэгч нь Санхүүгийн зохицуулагч байгууллагаас зөвшөөрөл авсан эсхүл бүртгүүлсэн байх ёстой ба ёс зүй, мэргэжлийн дараах таван үндсэн зарчмыг баримтална:

- Шударга байдал;
- Объектив байдал;
- Мэргэжлийн ур чадвар;
- Нууцлал;
- Мэргэжлийн байх.

Хөндлөнгийн хяналт шалгалтын төрлөөс хамааран хөндлөнгийн шинжээчид дараах зүйлийг хийнэ:

- Ногоон ба/эсвэл Нийгмийн бондын төслийн шалгуур үзүүлэлтийн чиглэлээр мэргэшсэн байх ба шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэх талаар дүгнэлт өгөх;
- Тогтвортой бондын хөрөнгөөр санхүүжүүлж буй ногоон/нийгмийн төслүүдийн байгаль орчны /нийгмийн үр ашиг, нөлөөллийг үнэлэх;
- Ногоон\ Нийгмийн бондын зарчмууд үндсэн дөрвөн бүрэлдэхүүн хэсэгтэй нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах/ хянах;
- Бонд гаргагчийн тодорхойлсон Төслүүдтэй холбоотой байгаль орчны

/нийгэмд учирч болзошгүй эрсдэлийг үнэлэх;

- Хяналтын тайландаа бонд гаргагчаас хараат бус ажиллах боломжтой эсэхээ тусгах.

Цаашлаад, хөндлөнгийн хяналтыг дараах хэлбэрүүдийн аль нэгээр нь эсвэл хэд хэдэн хэлбэрээр хийж болно:

Хоёрдогч талын санал: Тогтвортой байдал болон бусад асуудлаар туршлагатай зөвлөхүүд, аудитын компаниудын өгсөн саналыг хоёрдогч талын санал гэнэ. Энэ нь бондын Ногоон/Нийгэм бондын зарчмуудтай нийцэж байгаа эсэхийг үнэлэхээс гадна бонд гаргагчийн байгаль орчин, нийгмийн тогтвортой байдалтай холбоотой зорилго, стратеги, бодлого үйл явцын үнэлгээг багтааж болно. Өөрөөр хэлбэл энэ нь бондоор хөрөнгө босгож буй төслүүдийн байгаль орчин/ нийгмийн шинж чанарын үнэлгээ юм.

Баталгаажуулалт (Verification): Энэхүү баталгаажуулалтыг Аудитор эсхүл мэргэшсэн хөндлөнгийн байгууллагаар хийлгэх нь бонд гаргагчийн дотоод тогтолцооны уялдааг хангах сайжруулах баталгааг өгч хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлдэг.

Бонд гаргагчийн орлогын зарцуулалтыг хянах дотоод арга: Тогтвортой бондын орлогоос хөрөнгийн хуваарилалт, байгаль орчин/ нийгмийн нөлөөллийн тухай мэдэгдэл эсвэл тайланг Ногоон/ Нийгмийн бондын зарчмуудтай уялдуулах тухай баталгаа юм.

Гэрчилгээжүүлэлт(Certification): Мэргэшсэн гуравдагч этгээд бонд, түүний танилцуулга бодлогын баримт бичиг, орлогыг хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын стандартын дагуу тухайлбал, уур амьсгалын бондын санаачилгын стандартуудыг хангаж байгаа эсэхийг баталгаажуулдаг.

Зэрэглэлийн тайлан: Бонд гаргагч нь тогтвортой бонд, холбогдох бондын бодлогын баримт бичиг эсвэл орлогын ашиглалт зэрэг үндсэн шинж чанарыг мэргэшсэн судалгааны үйлчилгээ үзүүлэгч эсхүл зэрэглэл тогтоох байгууллага зэрэг мэргэшсэн гуравдагч этгээдээр тогтоосон оноо/үнэлгээний аргачлалын дагуу үнэлүүлж болно.

Нэмж дурдахад, Төвбанк болон Санхүүгийн зохицуулагч байгууллага нь бонд гаргагч

ногоон/ Тогтвортой хөгжилд чиглэсэн бондыг гэмт хэргээс олсон орлогыг угаах эрсдэлээс сэргийлэхийн тулд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн холбогдох шаардлагыг чанд мөрдөж байгаа эсэхийг баталгаажуулна. Шаардлагатай тохиолдолд холбогдох хууль эрх зүйн болон зохицуулалтын дагуу зөрчлийн шийтгэл ногдуулдаг.

4.2. КЕНИ УЛС

Кени Улсын Найроби үнэт цаасны бирж нь 2019 онд Тогтвортой санхүүжилтийн санаачилга, Уур амьсгалын бондын санаачилга, Кенийн банкнуудын холбоо, Голландын бизнес эрхлэгчдийн хөгжлийн банк зэрэг байгууллагуудын тусламжтайгаар Ногоон бонд хөтөлбөрийн хүрээнд ногоон бондын удирдамжийг гаргасан. Тус удирдамж нь Кени улсад ногоон бондын тогтолцоог бүрдүүлж, татан төвлөрүүлсэн бондын орлогыг байгаль орчинд ээлтэй төслүүдэд зарцуулах, энэхүү процессын ил тод, хариуцлагатай байдлыг баталгаажуулах зорилготой юм.

Кени Улсад ногоон бонд гаргах процесс нь нийт 6 үе шаттай:

1. Шаардлага хангасан ногоон төсөл, хөрөнгийг тодорхойлох;
2. Бонд гаргагч ногоон бондын танилцуулга холбогдох бодлогын баримт бичгийг боловсруулах;
3. Баталгаажуулалт хийлгэх;
4. Хяналт, тайлагнал;
5. Бондоо гаргах;
6. Орлогын ашиглалтад хяналт тавих, жил бүр тайлагнах.

Алхам 1: Орлого ашиглалт буюу шаардлага хангасан ногоон төсөл, хөрөнгийг тодорхойлох.

Найроби үнэт цаасны биржээс гаргасан удирдамжийн дагуу ногоон бондоос гаргасан төслүүд нь олон улсын Ногоон бондын зарчим, Уур амьсгалын бондын ангилал зүй болон Уур амьсгалын санхүүжилтийн үндэсний бодлого зэрэг бусад үндэсний ногоон стратеги, бодлогод тодорхойлсон ангилалд багтсан байна.

Уур амьсгалын бондын стандартын салбарын шалгуурууд нь төсөл, хөрөнгийн биелүүлэх ёстой тодорхой шаардлага, босгыг тодорхойлсон байдаг. Иймд шаардлага хангасан хөрөнгө, төслийг тодорхойлохын тулд байгууллага доторх санхүү болон байгаль орчны алба нягт хамтран ажиллах шаардлагатай.

Алхам 2: Ногоон бондын бодлогын баримт бичгийг боловсруулах.

Ногоон бондын бодлогын баримт бичигт төсөл, хөрөнгийн зохистой байдлыг тодорхойлоход ашиглах дотоод шийдвэр гаргах үйл явцыг тусган, баримтжуулж хадгалах ёстой. Ногоон бондын хүрээний бүтцэд дараах дөрвөн үндсэн зарчмыг заавал тусгана:

Хүснэгт 8. Кени Улсын ногоон/ тогтвортой гаргах үндсэн 4 зарчим

ЗАРЧИМ	ТОДОРХОЙЛОЛТ
1. ОРЛОГЫГ АШИГЛАЛТ	Орлогыг ногоон төслүүдийг санхүүжүүлэх эсвэл дахин санхүүжүүлэхэд зарцуулах ба бонд гаргагч ногоон төслийн шалгуурыг бүрэн тодорхойлж тусгах;
2. ТӨСЛИЙН ҮНЭЛГЭЭ, СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ҮЙЛ ЯВЦ	Энэ хэсэгт ногоон төслийг сонгоход шаардлагатай процесс, засаглалын механизмуудын талаар дурдана. Тухайлбал, ихэнх Бонд гаргагчид газар, хэлтсийн ахлахуудаас бүрдсэн Сонгон шалгаруулалтын хороог байгуулдаг. Тус хороо нь төсөл, хөрөнгийг сонгон шалгаруулах зөвлөмжийг гаргах ба батлуулахаар Удирдах зөвлөлд хүргүүлдэг. Бонд гаргагч бүр үндсэн төсөл, хөрөнгийг сонгох өөр өөр арга замтай байж болох ч сонгон шалгаруулалтын процессыг аль болох ил тод байлгах ёстой.
3. ОРЛОГЫН МЕНЕЖМЕНТ	Тус хэсэгт орлогыг дотооддоо удирдах, хянах зорилгоор бонд гаргагчийн авч хэрэгжүүлэх механизмуудыг тодорхойлно. Тухайлбал, бондын сан, хөрөнгө оруулалтыг удирдахад ашиглах систем, бодлого, мөн орлогыг хянах, хуваарилагдаагүй орлогыг удирдах зохицуулалт орно.
4. ТАЙЛАГНАХ	Бонд гаргагч нь бонд эзэмшигчдэд жилд хамгийн багадаа нэг удаа бондын хугацаанд орлого хуваарилсан төсөл, хөрөнгийн жагсаалтыг агуулсан Ногоон бондын тайланг гаргана. Уг тайланд төслүүдийн нөлөөллийн гүйцэтгэлийн тоон үзүүлэлтүүдийг оруулж болно. Нууцлалын тухай гэрээ эсвэл өрсөлдөөний асуудал нь задруулах дэлгэрэнгүй мэдээллийг хязгаарласан тохиолдолд мэдээллийг ерөнхий байдлаар танилцуулах боломжтой.

Эх сурвалж: NSE, Kenya Green Bond Guidelines Background Document

Алхам 3: Хөндлөнгийн хяналт, баталгаажуулалт

Найроби үнэт цаасны биржийн дүрмийн 2.13.1–д “Эрх олгох бонд гаргагч нь санхүүжүүлэх төслүүдийг Ногоон стандарт, удирдамжийн дагуу үнэхээр ногоон гэж ангилсан байх эсэх болон Ногоон бондын тогтолцооны дагуу төслийг сонгох, санхүүжилтийг хянах дотоод үйл явц, журам зэргийг баталгаажуулах бие даасан шалгагчийг томилно” гэж заасан байдаг. Үүний дагуу тус шалгалтыг ихэвчлэн байгаль орчны мэдээллийн томоохон баазтай байгууллагууд хийдэг. Тус байгууллага нь ногоон бондод бие даасан үнэлгээ хийх үүрэг хүлээдэг ба бонд гаргахаас өмнө баталгаажуулалтын тайланг (хөндлөнгийн хяналт гэж нэрлэдэг) гаргадаг. Ногоон бондын хөндлөнгийн хяналт нь дараах

хоёр ангиллын аль нэгэнд багтаж болно.

Хоёрдогч талын санал бодол: Энэ нь Ногоон бонд болон тэдгээрийн суурь төсөл, хөрөнгийн тогтвортой байдлын талаарх бие даасан, судалгаанд суурилсан үнэлгээ бөгөөд ихэвчлэн Ногоон бондын зарчимд хэр нийцтэй байгааг шалгана. Хоёрдогч талын саналын дүгнэлтийг ихэвчлэн бонд гаргахаас өмнө гаргадаг.

Баталгаажуулалтын тайлан: НББОУС 3000–д тодорхойлогдсон процессын дагуу хийгддэг бие даасан аудит бөгөөд энэ нь санхүүгийн бус түүхэн мэдээллийг боловсруулахад нягтлан бодогчдын ашигладаг стандарт юм. Баталгаажуулалтын саналууд нь бондын ногоон итгэмжлэл¹, Бонд гаргагчийн тогтоосон дотоод журмын аль алинд нь үнэлгээ хийдэг.

¹ Тус бонд нь ногоон бондын шаардлагыг хангаж байгааг илэрхийлсэн гэдгийг нотолсон баримт бичиг.

Баталгаажуулагч нь бондыг ногоон гэдгийг баталгаажуулахад чухал үүрэг гүйцэтгэдэг тул Найроби үнэт цаасны биржийн дүрэмд бие даасан баталгаажуулагчид тавигдах ерөнхий шаардлагыг тусгасан байдаг ба тус баталгаажуулалтыг Уур амьсгалын стандарт ба гэрчилгээжүүлэлтийн схем, эсвэл Найроби үнэт цаасны биржид бүртгэлтэй байгууллага хийдэг. Баталгаажуулагч нь Найроби үнэт цаасны биржээс зохион байгуулдаг сургалтад заавал хамрагдах ёстой.

Алхам 4: Орлогын менежмент – Хяналт, тайлагналыг тохируулах.

Ногоон бондын орлого хуваарилалтын талаарх мэдээллийг хөрөнгө оруулагчдад өгөх шаардлагатай ба үүнд дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй:

- Ногоон бондын орлогыг зөвхөн ногоон төсөлд зарцуулах ёстой тул ногоон бондын орлогыг ялгаж, зарцуулалтыг нь бүртгэх системтэй байх ёстой.
- Хөрөнгийн сан эсвэл төслийн нэрлэсэн үнэ нь бондын дүнтэй тэнцүү буюу түүнээс их байх ёстой.
- Ногоон бондын ашиглалтын хугацаанд орлогыг ногоон бус хөрөнгө оруулалтад хэзээ ч санаатайгаар байршуулахгүй байхын тулд хяналтын журмыг бий болгох ёстой.

Цаашлаад, орлогын менежментийн үйл явцыг тодорхойлохдоо бонд гаргагч нь хуваарилагдаагүй орлогыг хэрхэн удирдахаа шийдэх хэрэгтэй. Төсөл, хөрөнгөд хуваарилагдаагүй орлогын үлдэгдлийг богино хугацаат аливаа хөрөнгө оруулалт, хадгаламж болон бусад богино хугацаат хөрвөх чадварын хэрэгсэлд байршуулах ёстой ба орлогыг Ногоон бондын зарчмууд болон Уур амьсгалын бондын стандартад заасны дагуу 24 сараас илүү хугацаагаар хуваарилахгүй үлдээж болохгүй.

Алхам 5: Ногоон бонд гаргах.

Ногоон бондыг ердийн бондын адилаар гаргадаг. Санхүүгийн зохицуулагч байгууллага, Найробигийн үнэт цаасны бирж зэрэг зохицуулагч байгууллагуудаас Ногоон бондын гаргах зөвшөөрөл авдаг. Ингэхдээ Найробигийн үнэт цаасны бирж бүртгэлийн дүрмийн 2.14–д заасны дагуу дараах нэмэлт мэдээллийг хүргүүлнэ.

- Ногоон бондын байгаль орчны зорилтууд болон төслийн шаардлага, холбогдох шалгууруудыг тодорхойлох үйл явцын тухай мэдэгдэл;
- Бондын хөрөнгө, хөрөнгө оруулалтыг удирдах, хуваарилах, тайлагнахад ашиглах систем, бодлого, үйл явцын тухай мэдэгдэл;
- Гэрээт бие даасан баталгаажуулагчийн талаарх мэдээлэл;
- Санхүүжүүлэх төслүүд нь ногоон гэсэн шалгуурыг хангасан болохыг баталгаажуулсан тайлан;
- Ногоон бондын зах зээл, үнийн талаарх мэдээлэл.

Бондын зэрэглэлийг бусад бондтой адил үнэлдэг.

Алхам 6: Тогтмол мэдээлэх (жил бүр)

Бондын тайлан, үйл явцыг мэдээлэх процесс нь хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалт болон үндсэн төсөл, хөрөнгийн байгаль орчны гүйцэтгэл хоорондын шууд холбоог бий болгодог учраас чухал байдаг.

Үндэсний хөрөнгийн биржийн дүрмийн 2–р хэсэгт заасны дагуу Бонд гаргагч нь Санхүүгийн зохицуулагч байгууллага, Үндэсний хөрөнгийн бирж болон хөрөнгө оруулагчдад хамгийн багадаа жилд нэг удаа бонд, хөрөнгө ногоон төслүүдэд зохих ёсоор хуваарилагдсан талаарх мэдээллийг гаргаж өгөх ба бонд гаргагчийн вэбсайтаар

дамжуулан ил тод болгох ёстой. Бонд гаргагч нь хөрөнгө оруулагчид болон зохицуулагчид дор хаяж жилд нэг удаа тайлагнадаг байх ёстой боловч зарим Бонд гаргагчид жил бүр, бүр улирал бүр тайлагнаж болно. Тайланд дараах мэдээлэл заавал тусгагдсан байна:

- ✓ Аливаа төслийн тодорхойлолт, олгосон хөрөнгийн хэмжээ, түүний дотор төслийн төрөл, санхүүжилт, дахин санхүүжилтэд хуваарилагдсан орлогын хувь хэмжээ;
- ✓ Ногоон төсөл, хөрөнгөд гарсан аливаа томоохон өөрчлөлт;
- ✓ Төслүүд нь тодорхойлсон шаардлагад

нийцэхгүй болсон тохиолдолд бонд гаргагч нь орлогыг төсөлд дахин хуваарилсан эсэх;

- ✓ Хуваарилагдаагүй орлогын нийт үлдэгдэл, тэдгээрийг хэрхэн хадгалж байгаа талаар, түүнчлэн хуваарилагдаагүй орлогыг нүүрстөрөгчийн эрчимжсэн төслүүдийг санхүүжүүлэхэд зориулаагүй гэсэн баталгааг багтаах;
- ✓ Ногоон төслийн байгаль орчны гүйцэтгэлийн чанарын болон тоон үзүүлэлтүүд.

4.3. ЯПОН УЛС

Японы Ерөнхий сайд Suga 2020 оны 10 дугаар сард хийсэн бодлогын анхны илтгэлдээ 2050 он гэхэд нүүрстөрөгчгүй нийгмийг бий болгохын төлөө нүүрсхүчлийн хийг саармагжуулах зорилт дэвшүүлж байгаагаа албан ёсоор мэдэгдсэн. Ийнхүү 2021 онд Санхүүгийн үйлчилгээний агентлаг (FSA), Эдийн засаг, худалдаа, аж үйлдвэрийн яам болон Байгаль орчны яам хамтран 2050 он хүртэл нүүрстөрөгчийн хийг бууруулах зорилгод хүрэхэд чиглэсэн Уур амьсгалын шилжилтийн санхүүжилтийн удирдамжийг гаргасан.

Уур амьсгалын шилжилтийн санхүүжилтийн бонд гаргахад хөрөнгө оруулагчийн итгэх итгэлийг нэмэгдүүлэхийн тулд ICMA-аас гаргасан уур амьсгалын шилжилтийн санхүүжилтийн удирдамжийн дагуу дараах дөрвөн үндсэн зарчим гаргасан болно.

- *Зарчим 1:* Бонд гаргагчийн уур амьсгалын шилжилтийн стратеги ба засаглал;
- *Зарчим 2:* Бизнес загвар байгаль орчны материаллаг байдал;

- *Зарчим 3:* Уур амьсгалын шилжилтийн стратеги нь шинжлэх ухааны үндэслэлтэй байх, үүнд зорилтууд болон замын зураг орно;
- *Зарчим 4:* Хэрэгжилтийн ил тод байдал

Зарчим 1: Уур амьсгалын шилжилтийн стратеги ба засаглал

✓ Уур амьсгалын шилжилтийн санхүүжилт нь шилжилтийн стратегийн хэрэгжилтийг хангах буюу урамшуулахад чиглэгдэх ёстой. Шилжилтийн стратеги нь уур амьсгалтай холбоотой эрсдэлийг үр дүнтэй шийдвэрлэхэд бизнесийн загварыг өөрчлөх нь зөвхөн бизнесүүдийн өргөтгөл болох санаачилгуудаар хязгаарлагдахгүй ба өөр өөр хэтийн төлөвт суурилсан өөрчлөлт байж болно. Үүнд нүүрстөрөгч болон хүлэмжийн хийг бууруулахад ихээхэн ач холбогдолтой түлшний хувиргалт, шинэлэг технологи нэвтрүүлэх, үйлдвэрлэлийн үйл явц, бүтээгдэхүүний өөрчлөлтийг сайжруулах, шинэ салбарт бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, хангах зэрэг орж болно.

✓ Шилжилтийн стратегийн хэрэгжилт нь бизнесийн загварыг өөрчлөх замаар хөдөлмөр эрхлэлт, бүтээгдэхүүн үйлчилгээг тогтвортой хангах зэрэг уур амьсгалын өөрчлөлтөөс бусад нийгэм, байгаль орчинд нөлөөлөх тохиолдлуудыг тооцно.

✓ Шилжилтийн стратегийг боловсруулахдаа уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой хувилбаруудыг иш татсан байх ёстой.

✓ Шилжилтийн стратегийн үр нөлөөг сайжруулахын тулд санхүүжүүлэгч нь уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой үйл ажиллагаанд хяналт тавих Удирдах зөвлөл ба/эсвэл бусад хороон байгуулах зэрэг зохион байгуулалтын бүтцийг бий болгож үнэлэх, удирдахад үүрэг гүйцэтгэх ёстой.

✓ Шилжилтийн стратеги, төлөвлөгөө нь үр дүнтэй, хэрэгжихүйц байх ёстой. Иймд шилжилтийн стратеги, төлөвлөгөөг удирдлагын стратеги, бизнес төлөвлөгөө, тэр дундаа дунд хугацааны менежментийн төлөвлөгөөтэй уялдуулах хэрэгтэй.

Бие даасан хяналт, баталгаажуулалт

✓ Бонд гаргагч нь шилжилтийн стратегийн талаар бодитой үнэлгээ хийх хэрэгцээг тодорхойлсон тохиолдолд хөндлөнгийн байгууллагаар шилжилтийн стратегийг хянаж баталгаажуулахыг зөвлөдөг.

✓ Шилжилтийн стратегитай холбогдуулан ялангуяа дараах зүйлсийн талаар хөндлөнгийн байгууллагаар дүгнэлт гаргуулах хэрэгтэй. Үүнд:

✓ Богино, дунд болон урт хугацааны зорилтуудыг ерөнхий зорилготой уялдуулах;

✓ Зорилгодоо хүрэх Бонд гаргагчийн стратегийн найдвартай байдал;

✓ Шилжилтийн стратегийн менежментийн үйл явц, засаглалын зохистой байдал.

Зарчим 2: Бизнесийн загвар Байгаль орчны материаллаг байдал

✓ Шилжилтийн стратегид хүрэх санаачилга нь өнөөгийн болон ирээдүйн бизнесийн үндсэн үйл ажиллагааг өөрчлөхөд хувь нэмэр оруулах байх ёстой бөгөөд бизнесийн үйл ажиллагааг тодорхойлохдоо бонд гаргагч нь өөрийн дүгнэлтэд нөлөөлж болзошгүй уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой олон хувилбаруудыг авч үзэхийг хэрэгтэй.

✓ Материаллаг байдлыг тооцоолохын тулд тогтвортой байдлын тайлагналын стандарт шалгуурыг бий болгодог байгууллагаас өгсөн удирдамжийг ашиглах боломжтой.

✓ Ил тод байдалд бизнесийн үйл ажиллагааг тодорхойлоход ашигласан уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой хувилбарууд, эдгээр хувилбаруудыг сонгох үндсэн шалтгаануудын оруулах хэрэгтэй.

Зарчим 3: Уур амьсгалын шилжилтийн стратеги нь шинжлэх ухаанд тулгуурласан зорилт, замын зургийг багтаасан байх

✓ Бонд гаргагч нь шилжилтийн стратеги боловсруулахдаа шинжлэх ухаанд суурилсан зорилтуудыг иш татсан байх ёстой. Үүнд: 2050 он хүртэлх урт хугацааны зорилтуудаас гадна дунд хугацааны зорилтуудыг багтаана. Мөн эдгээр нь урт хугацааны туршид тогтвортой, тооны хувьд хэмжигдэхүйц байх ёстой.

✓ Эрчим хүчний болон үнэмлэхүй утгаар томъёолж болох хүлэмжийн хийг бууруулах зорилтууд нь байгаль орчинд ач холбогдолтой эсэхийг харгалзан үзэж, нийлүүлэлтийн хэлхээний ялгаруулалтын олон улсын стандартад нийцүүлэх ёстой.

✓ Бонд гаргагч нь богино, дунд болон урт хугацааны зорилтоо ил болгох ёстой. Урт хугацааны зорилтууд нь шинжлэх ухаанд суурилсан гэдгийг харуулахын тулд зорилтыг

тодорхойлоход ашигласан арга зүй, замын зургийг тайлбарлана.

Бие даасан хяналт, баталгаажуулалт

✓ Зорилтот зорилго, замын зургийн хувьд дараах асуудлаар хөндлөнгийн байгууллагаас дүгнэлт гаргуулах нь ач холбогдолтой гэж үздэг. Үүнд:

- Урт хугацааны зорилт нь шинжлэх ухаанд суурилсан зорилтуудтай нийцэж байгаа эсэх;
- Парисын хэлэлцээртэй нийцэж байгаа эсэх;
- Богино болон дунд хугацааны зорилтуудыг уур амьсгалын өөрчлөлтийн хувилбарын шинжилгээнд үндэслэн тооцоолсон хүлэмжийн хийн ялгаруулалтын таамаглалыг ашиглан тодорхойлсон эсэх;
- Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шинжилгээг ашигласан эсэх;
- Зорилтод ашигласан үзүүлэлтүүдийн бодит утгыг найдвартай аргуудыг ашиглан тоон байдлаар хэмжсэн эсэх;
- Урт хугацааны зорилтуудтай уялдуулан богино болон дунд хугацааны зорилтод хүрэхийн тулд хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах тусгай арга хэмжээ боловсруулсан эсэх.

Зарчим 4: Хэрэгжилтийн ил тод байдал

✓ Шилжилтийн стратегийг хэрэгжүүлэхдээ бонд гаргагч нь хөрөнгө оруулалтын үндсэн төлөвлөгөөний ил тод байдлыг хангах ёстой;

✓ Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд

зөвхөн хөрөнгө оруулалтын зардал, төдийгүй үйл ажиллагааны зардлын талаар багтаасан байх;

✓ Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд уур амьсгалтай холбоотой таамагласан үр дүн, нөлөөллийг тооцоолох арга, урьдчилсан нөхцөлийн хамт боломжтой бол тоон хэлбэрээр тусгах. Хэрэв тоон үзүүлэлтийг тодорхойлоход хүндрэлтэй байгаа бол хөндлөнгийн баталгаажуулалтын системийг ашиглан чанарын үнэлгээг хийх.

✓ Шилжилтийн стратегийг хэрэгжүүлэх нь уур амьсгалын өөрчлөлтөөс бусад хөдөлмөр эрхлэлт, байгаль орчин, нийгэмд сөрөг нөлөө үзүүлэх боломжтой бол ийм сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн аливаа зардлыг төлөвлөгөөнд нэмж оруулах.

✓ Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалтаас гарах үр дүн нь зорилттой нийцэж байх ёстой.

✓ Бонд гаргагч нь санхүүжилтийг баталгаажуулсны дараа анхны төлөвлөгөө болон бодит зарцуулалт, үр дүн, нөлөөллийн хоорондын зөрүүг мэдээлэх ёстой. Бондын орлогын ашиглалтад дахин санхүүжилт орсон тохиолдолд бонд гаргагч нь үндсэн шалтгаан, түүнд нөлөөлөгч хүчин зүйлс, эсвэл бусад холбогдох аргуудын дагуу тогтоосон хугацааны талаарх тайлбарыг өгнө.

✓ Нууцлал, өрсөлдөөний үүднээс олон нийтэд мэдээлэхэд хүндрэлтэй мэдээллийн агуулгыг хялбарчлах эсвэл олон нийтэд мэдээлэхгүйгээр зөвхөн хөрөнгө оруулагчид эсхүл хөндлөнгийн үнэлгээний байгууллагад мэдээлэх боломжтой.

V. ДҮГНЭЛТ, САНАЛ

Энэхүү судалгаагаар уур амьсгалын өрийн хэрэгслийн олон улсын стандарт, холбогдох баримт бичгүүд болон Япон, Кени, Маврики улсын ногоон/уур амьсгалын бондын сайн туршлагыг судаллаа.

Олон улсад ногоон/ уур амьсгалын бонд гаргахтай холбоотой Ногоон бондын зарчмууд, Уур амьсгалын бондын стандарт, Уур амьсгалын шилжилтийн санхүүгийн гарын авлага гэсэн 3 баримт бичгийг түгээмэл ашиглаж байна. Ногоон бондын зарчмууд нь зах зээлд ногоон бонд гаргах замыг тодорхой болгох, зах зээлийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, шударга байдлыг дэмжих зорилготой. Энэхүү удирдамж нь орлогын ашиглалт, төслийн үнэлгээ, сонгон шалгаруулалтын үйл явц, орлогын менежмент болон тайлагнах гэсэн үндсэн дөрвөн хэсгээс бүрддэг ба эдгээр нь уур амьсгалын бондын стандарт болон уур амьсгалын шилжилтийн санхүүгийн гарын авлагын суурь болдог. Уур амьсгалын бондын стандарт нь ногоон бонд болон бусад өрийн хэрэгсэлд итгэх хөрөнгө оруулагчийн итгэлийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх зорилгоор боловсруулсан бол Уур амьсгалын шилжилтийн санхүүжилт гэдэг нь байгууллагуудын хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулахаар урт хугацааны стратеги, санаачилгыг дэмжих санхүүжилтийг нэмэгдүүлэх зорилготой. Эдгээр баримт бичиг нь зах зээлд уур амьсгалын ногоон бонд эсхүл уур амьсгалын шилжилтийн бонд гаргах суурь зарчим, тавигдах шаардлага стандарт, процессыг тодорхойлсон байна.

Олон улсын туршлагаас авч үзвэл Кени Улсын хувьд 2019 онд ногоон бондын удирдамжаа гаргасан бол Маврики Улс нь Дэлхийн банк

болон Францын хөгжлийн агентлаг, НҮБ-ын дэмжлэгтэйгээр 2021 онд Ногоон бонд гаргагчдад зориулсан гарын авлагыг гаргажээ. Маврики Улсын удирдамжид Ногоон/Тогтвортой бонд гаргах үйл явцыг гаргахаас өмнөх, гаргах, гаргасны дараах үе шат хэмээн ерөнхий ангилсан бөгөөд бонд гаргах алхмууд болон ногоон бондоор санхүүжүүлэх болон санхүүжүүлэх боломжгүй төслүүдийн жагсаалт, ногоон бондын төрөл бүрийн хангах холбогдох стандартуудыг тодорхойлжээ. Мөн мэргэжлийн хөндлөнгийн байгууллагын баримтлах 5 үндсэн зарчим, хөндлөнгийн баталгаажуулалтын хэд хэдэн хэлбэрүүдийг санал болгосон. Харин Кени Улсын хувьд ногоон бонд гаргах 6 алхам байдаг бөгөөд алхам тус бүрд холбогдох шаардлагуудыг нарийн тодорхойлсон байна.

Цаашлаад Япон Улсын хувьд 2050 он гэхэд хүлэмжийн хийн ялгарлыг 0 түвшинд хүргэх зорилт дэвшүүлж байгаагаа 2021 онд албан ёсоор мэдэгдэж Уур амьсгалын шилжилтийг санхүүжилтийн бонд гаргахад хөрөнгө оруулагчийн итгэх итгэлийг нэмэгдүүлэхийн тулд ICMA-аас гаргасан уур амьсгалын шилжилтийн санхүүжилтийн гарын авлагыг суурь болгон үндсэн 4 бүрэлдэхүүн хэсэг бүхий удирдамж гаргасан. Тус удирдамжид ур амьсгалын шилжилтийн стратеги төлөвлөгөө, замын зураг түүний баталгаажуулалт, ил тод байдлыг хэрхэн хангах талаарх нарийн зохицуулалтуудыг тусгасан байна.

Ийнхүү ногоон/ уур амьсгалын бондын олон улсын зохицуулалтын туршлагад үндэслэн цаашид ногоон бонд болон уур амьсгалын шилжилтийн санхүүжилтийн орчныг дараах боломжит хувилбаруудаар зохицуулах боломжтой гэж дүгнэлээ:

- Чулуужсан түлш, химийн бодис, цемент, ган зэрэг эдийн засагт чухал ач холбогдолтой боловч богино хугацаанд нүүрстөрөгчийг бууруулах боломжгүй салбаруудын компаниудын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад чиглэсэн урт хугацааны стратеги төлөвлөгөөг дэмжих, хөрөнгө оруулалт татах боломжийг нэмэгдүүлэх уур амьсгалын шилжилтийн өрийн хэрэгсэлтэй холбоотой заалт, зохицуулалтыг өрийн хэрэгсэл бүртгэх журамд тусган бонд гаргагчдад зориулсан холбогдох гарын авлага, удирдамж боловсруулах;
- Ногоон/ Уур амьсгалын бонд гаргах процессыг тодорхой болгох, зах зээлийн ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор ногоон/ тогтвортой бондын удирдамжийг боловсруулах, холбогдох зохицуулалтыг өрийн хэрэгсэл бүртгэх журамд нэмж тусгах.
- Ногоон бондын удирдамж, зохицуулалтад нэмж тусгахад болон Уур амьсгалын шилжилтийн санхүүжилтийн зохицуулалтын орчныг бүрдүүлэхдээ дараах зохицуулалт, шаардлагуудыг тусгах саналыг боловсрууллаа:
- Ногоон бондын танилцуулга, бодлогын баримт бичигт заавал тусгах мэдээлэл, тавигдах шаардлага;
- Бондын зарцуулалтын ил тод байдлыг хангах үүднээс тодорхой давтамжтайгаар хөрөнгө оруулагчдад мэдээлэх тайлангийн бүрэлдэхүүн хэсэг, түүнд заавал тусгасан байх ёстой мэдээллийн жагсаалт;
- Бонд гаргагчид бондын орлогын 95–аас доошгүй хувийг Салбарын ангилал зүйн шалгуурыг хангасан төсөл, хөрөнгөд хуваарилсан байхыг шаардах ба хэрэв салбарын шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаагүй төсөл, хөрөнгийг санхүүжүүлсэн тохиолдолд бонд гаргагч нь ногоон бондын бодлогын баримт бичигт дэлгэрэнгүй тодруулга өгөх талаарх зохицуулалт;
- Салбарын шалгуурыг бүрэн хангаагүй аливаа төсөл, хөрөнгөд тавигдах ерөнхий шаардлага;
- Бонд гаргагчийн бондын орлогыг хуваарилж дуусах хугацааг тодорхойлон орлогын дахин хуваарилалт, хуваарилагдаагүй орлогыг богино хугацаат хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх талаарх зохицуулалт;
- Бонд гаргагчийн төсөл сонгон шалгаруулах шийдвэр гаргах үйл явц, төсөл, хөрөнгөд орлого хуваарилах процессыг баримтжуулж, хөтлөх талаарх зохицуулалт;
- Бонд гаргагчийн уур амьсгалын шилжилтийн стратеги, засаглал болон төлөвлөгөө замын зургийн шаардлагыг тодорхойлох;
- Байгууллагын стратеги, төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн ил тод байдлыг хангах чиглэлээр олон нийтэд мэдээлэх жилийн тайлан, тусгай зориулалтын тогтвортой байдлын тайлан, хөрөнгө оруулагчдад зориулсан танилцуулгад тавигдах шаардлага;
- Стратегийн төлөвлөлтөд хөндлөнгийн баталгаажуулалт хийх байгууллагад тавигдах шаардлага ба хяналт, дүгнэлтэд тавигдах шалгуурыг тодорхойлох.

VI. АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Bank of Mauritius (2021), “Guide for the issue of sustainable bonds in Mauritius.” Available at: https://www.bom.mu/sites/default/files/guide_sustainable_bonds_final_-_7_june_2021.pdf
- Climate Bond Initiative (2024), “Climate Bonds Standard V4.2.” Available at: <https://www.climate-bonds.net/climate-bonds-standard-v42>
- Financial Services Agency (2021), “Basic Guidelines on Climate Transition Finance.”, available at: <https://www.meti.go.jp/press/2021/05/20210507001/20210507001-3.pdf>
- ICMA (2021), “Green Bond Principles: Voluntary Process Guidelines for Issuing Green Bonds.” Available at: <https://www.icmagroup.org/assets/documents/Sustainable-finance/2022-updates/Green-Bond-Principles-June-2022-060623.pdf>
- ICMA (2023), “Climate Transition Finance Handbook: Guidance for Issuers”. Available at: <https://www.icmagroup.org/assets/documents/Sustainable-finance/2023-updates/Climate-Transition-Finance-Handbook-CTFH-June-2023-220623v2.pdf>
- NSE(2018), “Kenya Green Bond Guidelines Background Document.” Available at: <https://www.nse.co.ke/wp-content/uploads/gbpk-background-document-2.pdf>
- Sovereign Sustainable Finance Committee (2023), “Brazil’s Sovereign Sustainable Bond Framework”. Available at: https://sisweb.tesouro.gov.br/apex/f?p=2501:9::::9:P9_ID_PUBLICACAO_ANEXO:21043
- The National Treasury Kenya (2021), “Kenya sovereign green bond framework.” Available at: <https://www.fsdafrica.org/wp-content/uploads/2021/06/Kenya-Sovereign-Green-Bond-Framework.pdf>
- UNDP (2023), “Уур амьсгалын өөрчлөлтийн толь бичиг.” Эх үүсвэр: <https://www.undp.org/mn/mongolia/news/uur-amsgalyn-oorchloitiyn-tol-bichig-uur-amsgalyn-oorchloitiyn-asuudlaarkh-odor-tutmyn-garyn-avlaga>
- World bank (2021), “What You Need to Know About IFC’s Green Bonds.” Available at: <https://www.worldbank.org/en/news/feature/2021/12/08/what-you-need-to-know-about-ifc-s-green-bonds>.
- Bank of Mauritius (2021), “Guide for the issue of sustainable bonds in Mauritius.” Available at: https://www.bom.mu/sites/default/files/guide_sustainable_bonds_final_-_7_june_2021.pdf
- Financial Services Agency (2021), “Basic Guidelines on Climate Transition Finance.” Available at: <https://www.meti.go.jp/press/2021/05/20210507001/20210507001-3.pdf>
- ICMA (2021), “Green Bond Principles: Voluntary Process Guidelines for Issuing Green Bonds.” Available at: <https://www.icmagroup.org/assets/documents/Sustainable-finance/2022-updates/Green-Bond-Principles-June-2022-060623.pdf>

- ICMA (2023), “Climate Transition Finance Handbook: Guidance for Issuers.” Available at: <https://www.icmagroup.org/assets/documents/Sustainable-finance/2023-updates/Climate-Transition-Finance-Handbook-CTFH-June-2023-220623v2.pdf>
- NSE(2018), “Kenya Green Bond Guidelines Background Document.’ Available at: <https://www.nse.co.ke/wp-content/uploads/gbpk-background-document-2.pdf>
- Sovereign Sustainable Finance Committee (2023), “Brazil’s Sovereign Sustainable Bond Framework.” Available at: https://sisweb.tesouro.gov.br/apex/f?p=2501:9::::9:P9_ID_PUBLICACAO_ANEXO:21043
- The National Treasury Kenya (2021), “Kenya sovereign green bond framework.” Available at: <https://www.fsdafrica.org/wp-content/uploads/2021/06/Kenya-Sovereign-Green-Bond-Framework.pdf>
- UNDP (2023), “Уур амьсгалын өөрчлөлтийн толь бичиг.” Эх үүсвэр: <https://www.undp.org/mn/mongolia/news/uur-amsgalyn-oorchloltiyn-tol-bichig-uur-amsgalyn-oorchloltiyn-asuudlaarkh-odor-tutmyn-garyn-avlaga>
- World bank (2021), “What You Need to Know About IFC’s Green Bonds.” Available at: <https://www.worldbank.org/en/news/feature/2021/12/08/what-you-need-to-know-about-ifc-s-green-bonds>.